



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200

Утас/Факс: (976-11) 32 14 33.

Цахим шуудан: international@nso.mn.

Цахим хуудас: www.nso.mn

2022. 08. 25. № 01/403  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН  
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА ЖАМБАЛЫН ГАНБААТАР  
ТАНАА

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Үндэсний статистикийн хороо үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана” гэж заасны дагуу тус хорооны 2021 оны үйл ажиллагааны тайланг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт 01 хуудастай

Хүндэтгэсэн,

ДАРГА

Б.БАТДАВАА



142623500285



ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН

► **2021**

## АГУУЛГА

|  |     |
|--|-----|
| ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....   | iii |
| ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....  | v   |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....  | vi  |
| ӨМНӨХ ҮГ .....   | 1   |
| 2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ .....  | 2   |
| СТАТИСТИКИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....  | 3   |
| НЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....   | 4   |
| 1.1. АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ .....   | 4   |
| 1.2. АЛБАН ЁСНЫ БОЛОН ЗАХИРГААНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ .....  | 5   |
| 1.3. ТООЛЛОГО, ТҮҮВЭР СУДАЛГАА .....   | 6   |
| 1.4. ТООЦОО, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ .....  | 19  |
| 1.5. МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ .....   | 27  |
| ХОЁР. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА .....   | 30  |
| 2.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ .....  | 30  |
| 2.2. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ШИНЭЧЛЭЛ .....  | 32  |
| 2.3. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА .....  | 34  |
| 2.4. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА .....   | 35  |
| 2.5. ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ .....  | 37  |
| 2.6. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2022 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....                                  | 39  |
| ГУРАВ. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН<br>СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ..... | 40  |
| ОРШИЛ .....  | 40  |
| ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ .....   | 41  |
| ДҮГНЭЛТ .....  | 56  |
| САНАЛ .....  | 58  |
| ХАВСРАЛТ .....   | 59  |

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| ЗУРАГ 1. АНГИЛАЛ, АРГАЧЛАЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, АСУУЛГА, МАЯГТ ЗААВАР .....                                   | 4  |
| ЗУРАГ 2. ТХЗ-ЫН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ, 2021 он.....   | 5  |
| ЗУРАГ 3. АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН УЛСУУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН<br>МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ .....       | 5  |
| ЗУРАГ 4. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО.....  | 5  |
| ЗУРАГ 5. ААНБ-ЫН ТООЛЛОГОД АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН САН.....  | 7  |
| ЗУРАГ 6. ААНБ-ЫН ТООЛЛОГЫН ХЯНАЛТЫН САМБАР .....  | 7  |
| ЗУРАГ 7. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, тооллого явагдсан оноор.....                                    | 8  |
| ЗУРАГ 8. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, шалтгаанаар, 2021 он<br>.....                     | 8  |
| ЗУРАГ 9. АЖ АХУЙН НЭГЖИД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ, 2021 он .....   | 8  |
| ЗУРАГ 10. НИЙТ СҮРЭГТ 5 ХОШУУ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эцэст.....                                     | 9  |
| ЗУРАГ 11. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАХ ХЭРЭГЦЭЭ .....   | 11 |
| ЗУРАГ 12. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр.....                                      | 12 |
| ЗУРАГ 13. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр.....                                     | 12 |
| ЗУРАГ 14. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ, улирлаар, мянган хүн.....   | 13 |
| ЗУРАГ 15. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН,<br>улирлаар .....                    | 13 |
| ЗУРАГ 16. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, улирлаар.....                                      | 14 |
| ЗУРАГ 17. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар, судалгаа явагдсан<br>хугацаагаар.....       | 15 |
| ЗУРАГ 18. ЖИЛИЙН ИНФЛЯЦЫН БҮРЭЛДЭХҮҮН .....   | 16 |
| ЗУРАГ 19. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, хүйсээр .....   | 17 |
| ЗУРАГ 20. СҮҮЛИЙН 30 ХОНОГТ ЗАСГИЙН ГАЗРААС ХҮЛЭЭН АВСАН ДУНДАЖ<br>ШИЛЖҮҮЛГИЙН ХЭМЖЭЭ .....               | 18 |
| ЗУРАГ 21. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, хувиар.....  | 20 |
| ЗУРАГ 22. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ, дундаж бууралттай<br>хувилбараар, 2020-2050 он.....  | 22 |
| ЗУРАГ 23. ЯДУУРЛЫН ТҮВШИН .....   | 24 |
| ЗУРАГ 24. ЯДУУ ХҮН АМЫН ТАРХАЛТ, СУУРЬШЛААР .....   | 24 |
| ЗУРАГ 25. ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН АНГИЛСАН<br>ЗУРАГ.....                         | 25 |
| ЗУРАГ 26. ИХ ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, мэргэжлийн<br>чиглэлээр, 2013-2020, хувиар ..... | 26 |
| ЗУРАГ 27. СТАТИСТИКИЙН ЦАХИМ ХУУДАСНЫ ХАНДАЛТ .....   | 28 |
| ЗУРАГ 28. ШИНЭЧИЛСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ЗАГВАР .....  | 29 |
| ЗУРАГ 29. ҮСХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....  | 30 |
| ЗУРАГ 30. САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД, боловсролын түвшнээр .....  | 31 |
| ЗУРАГ 31. САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД, ажилласан жилээр.....   | 31 |
| ЗУРАГ 32. САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨДӨЛГӨӨН .....  | 32 |
| ЗУРАГ 33. ТӨРИЙН ИХ ӨГӨГДӨЛ – БҮРЭН ЗУРАГЛАЛ.....   | 33 |
| ЗУРАГ 34. ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БАЙГУУЛЛАГУУД .....   | 35 |

|  |    |
|--|----|
| ЗУРАГ 35. ШИЛЭН ДАНСНЫ АУДИТЫН ҮР ДҮН, 2016-2020 он.....   | 38 |
| ЗУРАГ 36. БАГИЙН ЗАСАГ ДАРГЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, дүнд эзлэх хувиар.....   | 48 |
| ЗУРАГ 37. БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН МЭРГЭЖИЛ, дүнд эзлэх хувиар.....  | 49 |
| ЗУРАГ 38. СУМЫН ТӨРИЙН САНГИЙН АЖИЛТНЫ АЖЛЫН АЧААЛАЛ, дүнд эзлэх хувиар .  | 51 |
| ЗУРАГ 39. АЙМАГ, ДҮҮРЭГ, НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС, ГАЗРЫН АЖИЛТАН,<br>насны бүлгээр, дүнд эзлэх хувиар.....  | 53 |
| ЗУРАГ 40. ОРОН НУТАГ ДАХЬ НЭГЖИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДСЭН ЦАЛИНГИЙН<br>ХАРЬЦУУЛАЛТ, тухайн албан тушаалын цалингийн эхний шатлалаар, төгрөгөөр, 2021.12.31-<br>ний байдлаар..... | 55 |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....  | 9  |
| ХҮСНЭГТ 2. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр  | 15 |
| ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ТООЦООНЫ МАКРО МАТРИЦ, 2020 он .....  | 20 |
| ХҮСНЭГТ 4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ЗАРИМ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2020-2050 он .  | 22 |
| ХҮСНЭГТ 5. СОНГОСОН ТӨСЛҮҮДИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ,<br>ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ .....                                  | 25 |
| ХҮСНЭГТ 6. ИХ ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, 2021 ОНЫ<br>БАЙДЛААР, МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР, дүнд эзлэх хувиар ..... | 27 |
| ХҮСНЭГТ 7. САЛБАРЫН БАТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, сая төгрөг .....  | 35 |
| ХҮСНЭГТ 8. ҮСХ-НЫ 2016-2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ<br>ХИЙСЭН СЭДЭВ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА .....                   | 40 |
| ХҮСНЭГТ 9. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ .....   | 43 |
| ХҮСНЭГТ 10. АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН<br>ХААГЧДЫН ТОО.....                                  | 52 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

|               |   |
|---------------|---|
| ААН           | Аж ахуйн нэгж   |
| ААНБ          | Аж ахуйн нэгж, байгууллага  |
| АНДО          | Ази Номхон Далай Орнууд   |
| АНДЭЗНК       | Ази Номхон Далай Орнуудын Эдийн засаг, нийгмийн комисс  |
| АХБ           | Азийн хөгжлийн банк   |
| АХС           | Ажиллах хүчний судалгаа   |
| БНСУ          | Бүгд Найрамдах Солонгос Улс   |
| БОАЖЯ         | Байгаль орчин, аялал жуулчлалын яам   |
| БОЭЗДС        | Байгаль орчин, эдийн засгийн дансны систем  |
| БХБЯ          | Барилга, хот байгуулалтын яам   |
| БХЯ           | Батлан хамгаалах яам  |
| БШУЯ          | Боловсрол, шинжлэх ухааны яам   |
| ГЕГ           | Гаалийн ерөнхий газар   |
| ГТСМТТ        | Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв  |
| ГХЗЗГ         | Газрын харилцаа, зураг зүйн газар   |
| ГХЯ           | Гадаад харилцааны яам   |
| ДБ            | Дэлхийн банк  |
| ДНБ           | Дотоодын нийт бүтээгдэхүүн  |
| ЗГХЭГ         | Засгийн газрын хэрэг эрхлэх газар   |
| ЗТХЯ          | Зам тээвэр, хөгжлийн яам  |
| НДЕГ          | Нийгмийн даатгалын ерөнхий газар  |
| НҮБ           | Нэгдсэн Үндэстний Байгууллага   |
| НҮБХХААБ      | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага   |
| ОУВС          | Олон улсын валютын сан  |
| ОУЦХБ         | Олон улсын цахилгаан холбооны байгууллага   |
| ӨНЭЗС         | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа   |
| ПАРИС/PARIS21 | XXI зууны Статистикийн төлөөх түншлэл/The Partnership in Statistics for Development in the 21 <sup>st</sup> Century |
| СБРС          | Статистикийн бизнес регистрийн сан  |
| СЗХ           | Санхүүгийн зохицуулах хороо   |
| СХТ           | Салбар хоорондын тэнцэл   |
| СҮАЕЗ         | Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар   |
| СЯ            | Сангийн яам   |
| ТЕГ           | Татварын ерөнхий газар  |
| ТЕЗ           | Төсвийн ерөнхийлөн захирагч   |
| ТХЗ           | Тогтвортой хөгжлийн зорилго   |
| УБЕГ          | Улсын бүртгэлийн ерөнхий газар  |

|          |   |
|----------|---|
| УИХ      | Улсын Их Хурал  |
| УУХҮЯ    | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам   |
| ҮСХ      | Үндэсний статистикийн хороо   |
| ҮТС      | Үндэсний тооцооны систем  |
| ХАА      | Хедее аж ахуй   |
| ХАОСТ    | Хүн ам, орон сууцны тооллого  |
| ХБНГУ    | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс  |
| ХЗДХЯ    | Хууль зүй, дотоод хэргийн яам   |
| ХНХЯ     | Хеделмер, нийгмийн хамгааллын яам   |
| ХХААХҮЯ  | Хүнс, хедее аж ахуй, хенген үйлдвэрийн яам                                  |
| ХХМТГ    | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар                               |
| ЦЕГ      | Цагдаагийн ерөнхий газар  |
| ШЕЗ      | Шүүхийн ерөнхий зөвлөл  |
| ЭЗБХ     | Эдийн засгийн байнгын хороо   |
| ЭМЯ      | Эрүүл мэндийн яам   |
| ЭХЯ      | Эрчим хүчний яам  |
| ЮНЕСКО   | Нэгдсэн Үндэстний Байгууллагын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага |
| CAPI     | Computer Assisted Personal Interviewing                                     |
| CATI     | Computer Assisted Telephone Interviewing                                    |
| CSPro    | Census and Survey Processing System   |
| IAEG-SDG | Inter-agency and Expert Group on SDG  |
| GAMSO    | Generic Activity Model for Statistical Organisations                        |
| GSBPM    | Generic Statistical Business Process Model                                  |
| SDMX     | Statistical Data and Metadata eXchange                                      |
| SPS      | Statistical Production System   |
| SPSS     | Statistical Package for Social Science                                      |
| SWIFT    | Survey of Well-being via Instant and Frequent Tracking                      |
| UI/UX    | User Interface/User eXperience  |



## ӨМНӨХ ҮГ

Үндэсний Статистикийн Хорооноос 2021 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг системчилсэн үнэлгээний хамт Танд өргөн барьж байна. Энэхүү тайланд “Статистикийн тухай хууль”-д заасан тооллого, судалгаа, шинжилгээний ажлуудын хэрэгжилтээс гадна тус салбарыг шинэчлэх, хөгжүүлэх чиглэлээр өнгөрсөн онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг багтаасан болно.

Албан ёсны статистикийг хөгжүүлэх дэлхийн нийтлэг чиг хандлага, дотоодын хэрэгцээнд нийцүүлэн бид өнгөрсөн онд статистикийн салбарын дунд хугацааны зорилго, зорилтыг тодорхойлж, 2021-2025 оны стратеги төлөвлөгөөг баталлаа. Уг стратеги төлөвлөгөөнд статистикийн салбарын 1. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, 2. Хүний нөөцийн хөгжлийг хангах, 3. Дэд бүтцийг сайжруулах болон 4. Статистикийн мэдээлэл эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Өнгөрсөн онд салбарын дэд бүтцийг сайжруулах, үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилтын хүрээнд үйл ажиллагааг бүрэн автоматжуулах “Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн систем (SPS)”-ийг Дэлхийн банкны Ухаалаг Засаг төслийн санхүүжилтээр нэвтрүүллээ. Түүнчлэн төрийн байгууллагуудын мэдээллийн санг холбож, нэгдсэн санг бий болгох “Төрийн их өгөгдөл” төслийг хэрэгжүүлэх ажлын эхлэлийг тавилаа. Энэхүү төсөл хэрэгжсэнээр статистик мэдээллийн хурд, хамрах хүрээ өргөжиж, зардал буурахаас гадна төрийн болон хувийн хэвшлийн нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх мэдээллийн нарийвчилсан эх үүсвэр бүрэлдэх юм.

Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Үндэсний статистикийн хороо 2021 онд нийт 2 тооллого, 27 түүвэр судалгааг амжилттай зохион байгууллаа. Тухайлбал аж ахуйн нэгж, байгууллагын ээлжит тооллого, мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого болон төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа, олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа<sup>нэмэх</sup>, өрхөд суурилсан мэдээлэл, харилцаа холбооны технологийн судалгаа, бичил уурхай эрхлэгчдийн судалгааг хийж гүйцэтгэв. Мөн хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны албан ёсны статистикийн 53 төрлийн мэдээг өрх, аж ахуйн нэгжээс, яам, агентлаг, төрийн бусад байгууллагаас 365 маягтаар 7 хоног, 14 хоног, сар, улирал, жилийн давтамжтай нэгтгэн боловсруулж, үр дүнг хэрэглэгчдэд хүргэлээ.

Түүнчлэн ДНБ-ий суурь оны тооцоо, нийгмийн тооцооны матриц, ядуурлын тооцоо, хүн амын болон боловсролын хэтийн тооцоог шинэчилж, төрийн байгууллагуудын бодлого төлөвлөлтөд шаардлагатай мэдээллийг бий болгов.

Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу бүх нийтийн бэлэн байдалд шилжиж, хатуу хөл хорио тогтоосон хугацаанд статистик мэдээлэл цуглуулах ажлыг мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан тасралтгүй явуулж чадлаа.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд НҮБ болон олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн Хөдөө аж ахуйн статистикчдын 29 дүгээр чуулганыг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран Улаанбаатар хотод анх удаа амжилттай зохион байгууллаа. Мөн тус Хороо нь Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтийн Бүс дундын шинжээчдийн бүлэг (IAEG-SDG)-ийн 2021-2023 онд Зүүн Азийг төлөөлөх гишүүнээр шинээр сонгогдон ажиллаж байна.

Статистикийг хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх зорилгоор статистик мэдээлэл түгээх хэлбэрийг шинэчилж, хэрэглэгчдийн статистикийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгууллаа.

Үндэсний статистикийн хороо нь 2022 онд статистикийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, чадавхыг бэхжүүлэх, үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн санг үүсгэх “Төрийн их өгөгдөл” төслийг хэрэгжүүлэх, үндэсний хэмжээнд өгөгдлийн нэгдсэн стандарт, ангилал, код нэвтрүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

ДАРГА

Б.БАТДАВАА

## 2021 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

1. Дэлхийн статистикийн хөгжлийн чиг хандлага, албан ёсны статистикийн шинэчлэлд нийцүүлэн статистикийн салбарын дунд хугацааны зорилго, зорилтыг тодорхойлж, “Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөө”-г боловсруулан баталлаа.
2. Уялдаа холбоотой, чанарын шаардлагыг хангасан мэдээлэлд үндэслэн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад шаардлагатай, төсвийн зардлыг хэмнэх, мэдээллийн давхардал, ачааллыг бууруулах, хэрэглэгчдэд мэдээллийг цаг тухайд нь хүргэх боломжийг бүрдүүлэх “Төрийн их өгөгдөл” төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэв.
3. Программ хангамж, өгөгдлийн шинжилгээг хослуулан албан ёсны статистикийн ерөнхий стандарт загвар (GSBPM)-т нийцсэн өгөгдөл, мэдээллийн урсгалыг бүрэн автоматжуулах “Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн систем (SPS)”-ийг нэвтрүүлж, 2021 онд албан ёсны 10 мэдээ, 23 маягтыг системд нэвтрүүллээ.
4. Албан ёсны статистикийн шинэчлэлийн стандарт загварыг нэвтрүүлэхээр байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг шинэчлэн өгөгдлийн засаглал, өгөгдлийн шинжилгээг эрхлэн хөгжүүлэх нэгжийг шинээр бий болгон ажиллаж байна.
5. Тооллого судалгааг зохион байгуулж явуулах чиг үүргийн хүрээнд 2 тооллого, 27 түүвэр судалгаа явуулж, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн талаарх судалгаа шинжилгээний 12 ажил, 4 тооцооллыг хийж, хэрэглэгчдэд хүргэсэн.
6. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Ази, номхон далайн орнуудын Хөдөө аж ахуйн статистикчдын 29 дүгээр чуулганыг Улаанбаатар хотод анх удаа зохион байгууллаа.
7. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн Бүс дундын шинжээчдийн бүлэг (IAEG-SDG)-ийн 2021-2023 онд Зүүн Азийг төлөөлөх гишүүнээр сонгогдсон нь олон улсын түвшинд Монгол Улсын статистикийн байгууллагын оролцоо, нэр хүндийг бэхжүүлэх алхам болов.
8. Хэрэглэгчдэд статистикийн мэдээллийг ойлгомжтой болгох, бүтээгдэхүүнийг сайжруулах зорилгоор байгууллагын брэнд номыг шинэчлэн мөрдөж, хэрэглэгчдийн онцлогт нийцсэн, тэдэнд чиглэсэн бүтээл, мэдээллийг бэлтгэн хүргэж, сургалт, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав.

## СТАТИСТИКИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

### АЛСЫН ХАРАА

Статистикийн мэдээллийн хэрэглэгчдийг чанартай тоон мэдээллээр хангаж, нотолгоонд суурилсан бодлого, шийдвэрийн залгамжийг тасралтгүй хадгалан, статистикийн чадавхаараа дэлхийд тэргүүлнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид Монгол Улсын статистикийн мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ.

### СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай статистикийн мэдээллийг эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ.

#### ЗОРИЛТ 1

Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

#### ЗОРИЛТ 2

Хүний нөөцийн хөгжлийг хангах

#### ЗОРИЛТ 3

Дэд бүтцийг сайжруулах

#### ЗОРИЛТ 4

Статистикийн мэдээлэл эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох

### 2021 ОНЫ ЗОРИЛГО

Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх

#### ЗОРИЛТ 1

Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж, мөрдүүлэх

#### ЗОРИЛТ 2

Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээлэл, тооллого, судалгааг зохион байгуулах, үр дүнг боловсруулах, тархах

#### ЗОРИЛТ 3

Мэдээлэл тархаалтын олон улсын стандартад нийцсэн тогтолцоог бүрдүүлэх

#### ЗОРИЛТ 4

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх

#### ЗОРИЛТ 5

Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх

## НЭГ. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 1.1. АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ

Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тооллого, судалгааны мэдээллийг цуглуулж, нэгтгэхэд ҮСХ-ны баталсан болон зөвшөөрсөн 78 аргачлал, 541 маягт, түүнийг нөхөх заавар, 11 ангиллыг мөрдөж байна. Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн баталж, мөрдүүлэх ажлын хүрээнд 2021 онд 2 ангилал, 6 аргачлал, 16 багц асуулга, маягт, түүнийг нөхөх зааврыг шинээр болон шинэчлэн баталж, статистикийн 6 бүтээгдэхүүний тооцоог шинэчиллээ. Эдгээрээс шинээр 2 ангилал, 5 аргачлал, 6 багц асуулга, маягт, нөхөх зааврыг шинээр боловсруулж баталлаа (Хавсралт 1).

ЗУРАГ 1. АНГИЛАЛ, АРГАЧЛАЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, АСУУЛГА, МАЯГТ ЗААВАР



Олон улсын стандартад нийцүүлэн статистикийн аргачлал, ангилал, түүврийн арга зүйг сайжруулан боловсруулснаар албан ёсны статистикийн тооллого, судалгаа, мэдээний хүрээ тэлж, хэрэглэгчдэд тархаах үзүүлэлтийн тоо, хүртээмжийг нэмэгдүүллээ. Тухайлбал, Дэлхийн ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тооцох, өргөжүүлэх зорилгоор 2021 онд ҮСХ-ноос баталсан 5 аргачлал, тооллогын 1 асуулгад манай улсад тооцохгүй байгаа болон сайжруулах шаардлагатай 17 үзүүлэлтийг тооцох арга зүйг тусгасан болно. (Хавсралт 2, 3)

**ЗУРАГ 2. ТХЗ-ЫН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ, 2021 он**



**ЗУРАГ 3. АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН УЛСУУДЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ**



Эх сурвалж: НҮБ -ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс, ТХЗ гарц -Ази номхон далайн, 2020

## 1.2 АЛБАН ЁСНЫ БОЛОН ЗАХИРГААНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

ҮСХ нь албан ёсны статистикийн 48 багц үзүүлэлтийг тооцох мэдээллийг анхан шатны бүртгэл, захиргааны болон албан ёсны мэдээ, тооллого, түүвэр судалгаагаар цуглуулан боловсруулсан. 2021 онд цуглуулсан мэдээллийн 71.9 хувь нь яам, агентлаг, төрийн бусад байгууллагаас цуглуулсан, 29.1 хувь нь аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсээр дамжуулан цуглуулсан мэдээлэл байна. Үүнд:

- Хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны албан ёсны статистикийн 53 төрлийн мэдээг 51 маягтаар аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсээр дамжуулан өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас 7 хоног, 14 хоног, сар, улирал, хагас жил, жилээр,
- Яам, агентлаг, төрийн бусад байгууллага зэрэг нийт 37 байгууллагаас хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, боловсрол, шинжлэх ухаан, соёл, урлаг, спорт, техник, технологи, мөнгө, зээл, санхүү, гааль, даатгал, татвар, байгаль орчин, шүүхийн статистикийн мэдээллийг 365 маягтаар 14 хоног, сар, улирал, жилээр.

**ЗУРАГ 4. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО**



Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгыг сар бүр, ДНБ-ий тооцоог улирал бүр, статистикийн жилийн

эмхэтгэл, салбарын танилцуулгыг жил бүр, тооллого, судалгааны үр дүн, хэтийн тооцоо, судалгаа, шинжилгээний ажлыг тухай бүр хэрэглэгчдэд хүргэж ажиллалаа.

Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулж эдийн засаг, хүн ам, нийгмийн 1921-2021 оны статистик үзүүлэлтээр “Монгол Улс 100 жилд” эмхэтгэлийг бэлтгэн цахим хэлбэрээр тархаалаа.

### 1.3 ТООЛЛОГО, ТҮҮВЭР СУДАЛГАА

ҮСХ-ноос 2021 онд 2 тооллого, 27 түүвэр судалгааг явууллаа. Үүнээс Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Монголбанкттай хамтран 6, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, Дэлхийн банк, ХБНГУ-ын Боловсрол судалгааны яам, Цаг уурын хүрээлэнтэй хамтран 6 судалгааг тус тус зохион байгууллаа.



#### ТООЛЛОГО - 2

- ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 2021 оны ээлжит тооллого
- Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн жилийн эцсийн тооллого

**Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 2021 оны ээлжит тооллого.** ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны чиглэл, байршил, бизнесийн төлөв байдал, хандлагыг тодорхойлох, тэдгээрийн мэдээллийг бий болгох зорилгоор Засгийн газрын 2021 оны 315 дугаар тогтоолын дагуу тооллогыг 2021 оны 11 дүгээр сард цахим хуудаст суурилсан асуулгаар дамжуулан хийлээ. Энэ удаагийн тооллогоор аж ахуйн нэгж, төсвийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, нэгж, төлөөлөгчийн газрын болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн гэсэн 5 төрлийн асуулгаар цар тахлын нөлөөлөл, бизнесийн төлөв байдал, хандлага, инновац, судалгаа хөгжүүлэлтийн мэдээлэл, мэдээллийн технологи, өгөгдлийн сан, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн мэдээллийг цуглуулснаараа онцлогтой юм.

## ЗУРАГ 5. ААНБ-ЫН ТООЛЛОГОД АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН САН



## ЗУРАГ 6. ААНБ-ЫН ТООЛЛОГЫН ХЯНАЛТЫН САМБАР

|                       | НИЙТ | ААНТ-1 | ААНТ-2 | ААНТ-3 | ААНТ-4 |      |     |       |    |      |
|-----------------------|------|--------|--------|--------|--------|------|-----|-------|----|------|
| НИЙТ ХҮРЭЭНД БАЙГАА   | 100% | 206526 | 82%    | 186207 | 2%     | 4978 | 14% | 32101 | 1% | 3139 |
| ХУВААРИЛАГУЙ          | 0%   | 41     | 56%    | 23     | 20%    | 8    | 20% | 8     | 5% | 2    |
| ХУВААРИЛСАН           | 0%   | 321    | 90%    | 297    | 0%     | 8    | 10% | 32    | 1% | 2    |
| ДУТУУ ХАВГАЛСАН       | 0%   | 216    | 90%    | 195    | 0%     | 8    | 10% | 21    | 0% | 0    |
| НИЙТ ХАМРАГДСАН       | 100% | 227976 | 82%    | 187714 | 2%     | 4978 | 14% | 32047 | 1% | 3137 |
| БҮРЭН ХАВГАЛСАН       | 0%   | 126    | 85%    | 107    | 6%     | 7    | 8%  | 10    | 2% | 2    |
| ДУУСГАСАН             | 8%   | 1787   | 81%    | 1541   | 2%     | 407  | 10% | 1752  | 1% | 88   |
| БАТАЛГААЖУУЛСАН       | 72%  | 163817 | 83%    | 136131 | 3%     | 4136 | 13% | 22100 | 1% | 1538 |
| ШУЦЛСАН               | 0%   | 146    | 62%    | 90     | 17%    | 23   | 10% | 28    | 2% | 3    |
| ДАХИН БАТАЛГААЖУУЛСАН | 0%   | 88     | 42%    | 37     | 42%    | 37   | 10% | 8     | 6% | 5    |
| ШАЛТГААНТАЙ           | 20%  | 40526  | 78%    | 31918  | 1%     | 372  | 18% | 8188  | 3% | 1993 |


**Тайлангийн жагсаалт**

0. ААН-ын ХАМРАГДАЛТ, Дүүргээр, өдрөөр
1. ТООЛОГЧИЙН ЖАГСААЛТ
2. ТООЛОГЧИЙН ЯВИЛ
3. ААН-ын ХАМРАГДАЛТ, засаг захиргааны нэгжээр, өдрөөр
4. ААН-ын ХАМРАГДАЛТ, засаг захиргааны нэгжээр, мялаар
5. ААН-ын ХАМРАГДАЛТ, тоологчсор, өдрөөр



Тооллогод улсын хэмжээнд 227.9 мянган ААНБ-ыг хамруулснаас 84.2 хувь нь аж ахуйн нэгж, 13.3 хувь нь төрийн бус байгууллага, 2.5 хувь нь төсвийн байгууллага байна.

**ЗУРАГ 7. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, тооллого явагдсан оноор**




Аж ахуйн нэгж, байгууллагын тоо 1998 оноос 9.5 дахин, 2016 оноос 51.6 хувиар нэмэгджээ.

**ЗУРАГ 8. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛААГҮЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО, шалтгаанаар, 2021 он**



Үйл ажиллагаа явуулаагүй 94.7 мянган аж ахуйн нэгжийн 45.9 мянга (48.5%) нь түр зогссон, 29.4 мянга (31.1%) нь эхлээгүй, 18.8 мянга (19.8%) нь бүрэн зогссон, 0.6 мянга (0.6%) нь бусад шалтгаантай байна. Сүүлийн хоёр жил дараалан үйл ажиллагаа явуулаагүй ААН-ийн 14.9 мянга (14.1%) нь татан буугдах хүсэлтэй байна.

**ЗУРАГ 9. АЖ АХУЙН НЭГЖИД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨ, 2021 он**



Сүүлийн 2 жил үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 39.5 мянга (85.9%-д) нь Ковид-19 цар тахал үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн гэсэн байна. Үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн 44.4 хувь нь хатуу хөл хорионы үед үйл ажиллагаагаа хязгаарлагдмал хүрээнд явуулжээ.

**Мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн жилийн эцсийн тооллого.** Мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлтийг улс, бүс, засаг захиргааны нэгж, мал, амьтдын төрлөөр, мал сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтийг гаргах зорилгоор уг тооллогыг 2021 оны 12 дугаар сард цар тахлын халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгууллаа. Тооллогод улсын төсвөөс 28.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 633.7 сая төгрөг, нийт 662.5 сая төгрөгийг зарцуулсан. Тооллогод орон нутагт 2,970 чиглэлд нийт 11,667 хүн ажилласан. Мэдээлэл цуглуулалтын чанарыг нэмэгдүүлэх зорилгоор тооллогын явцын хяналтыг ҮСХ болон ХХААХҮЯ-наас Өмнөговь, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Орхон аймгуудад, орон нутгийн тооллогын комиссоос сонгосон сумдад тус тус хийсэн. Төв, орон нутгийн тооллогын комиссоос нийт 246.3 мянган малтай өрхөөс санамсаргүй байдлаар 14.4 мянган өрхийг сонгон хяналт хийж, тооллогын явц, зохион байгуулалт, тооллогын үе шатанд гарсан алдаа,

дутагдал, тэдгээрийг залруулсан байдалтай танилцан, заавар зөвлөмжийг өгч ажиллалаа.


Тооллогоор 67.3 сая толгой мал, үүнээс адуу 4.3 сая, үхэр 5.0 сая, тэмээ 454.0 мянга, хонь 31.1 сая, ямаа 26.5 сая болжээ. Улсын хэмжээнд мал ундаалах зориулалт бүхий 62.5 мянган худаг, 82.9 сая толгой малын багтаамж бүхий 250 мянган хашаа тоологдсон байна.

#### ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт                                      | Бүгд     | Малын төрлөөр |         |       |          |          |
|---|----------|---------------|---------|-------|----------|----------|
|   |          | Адуу          | Үхэр    | Тэмээ | Хонь     | Ямаа     |
| Малын тоо                                     | 67 343.8 | 4 324.4       | 5 022.2 | 454.0 | 31 087.0 | 26 456.1 |
| Хээлтэгч мал                                  | 30 784.5 | 1 481.8       | 2 035.2 | 169.5 | 14 752.2 | 12 345.7 |
| Төллөсөн хээлтэгч                             | 21 974.5 | 976.2         | 1 444.3 | 68.5  | 11 190.7 | 8 294.8  |
| Төллөлтийн хувь                               | 74.1     | 71.2          | 78.5    | 40.8  | 80.2     | 67.3     |
| Бойжуулсан төл                                | 20 321.6 | 919.3         | 1 378.0 | 64.9  | 10 457.5 | 7 502.0  |
| Бойжилтын хувь                                | 92.3     | 94.2          | 95.4    | 94.7  | 93.2     | 90.2     |
| Хорогдсон том мал                             | 3 012.3  | 118.4         | 188.4   | 22.2  | 1 123.5  | 1 559.9  |
| Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь | 4.5      | 2.9           | 4.0     | 4.7   | 3.7      | 5.6      |
| Малтай нэг өрхөд ногдох малын тоо             | 272      | 17            | 20      | 2     | 125      | 107      |
| Малчин нэг өрхөд ногдох малын тоо             | 323      | 20            | 23      | 2     | 150      | 128      |

Нийт мал сүрэгт 2021 онд 5 төрлийн малын эзлэх хувийг мал хувийн өмчид шилжиж эхэлсэн 1990 онтой харьцуулахад ямааны эзлэх хувь 19.5 нэгж хувиар өсөж, хониных 12.2 нэгж хувь, үхрийнх 3.6 нэгж хувь, адууных 2.3 нэгж хувь, тэмээнийх 1.4 нэгж хувиар буурсан байна.

#### ЗУРАГ 10. НИЙТ СҮРЭГТ 5 ХОШУУ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эцэст



Нийт сүрэгт хонь, ямааны харьцаа 1990 он хүртэл 3 хонинд нэг ямаа ногдож, зохистой харьцааг хадгалж байсан боловч ноолуурын үнэ өссөнтэй холбоотой ямааны тоо 1993 оноос өсөж, 2021 онд 52.48 харьцаатай болсон байна.



Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын нэгдсэн үр дүн. Хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн үр дүнг Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулах ажлыг зохион байгууллаа. Тооллогын үр дүнгээр Хүн ам зүйн үндэсний атлас, Өрх гэр бүлийн байдал, Хүүхэд, залуучууд, Өндөр настан, Шилжих хөдөлгөөн, суурьшил, Хүн амын 2020-2050 оны шинэчилсэн хэтийн тооцоо, Боловсролын 2020-2050 оны хэтийн

тооцоо, Боловсрол, бичиг үсгийн мэдлэг, Жендэрийн тэгш байдал, Интернэт, гар утасны хэрэглээ, Эдийн засгийн идэвх зэрэг сэдэвчилсэн 13 судалгааг монгол, англи хэлээр боловсруулан хэрэглэгчдэд тархаасан.



**Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа.** Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлж, Монгол хэлний тухай хуулийг дагаж мөрдөхөд бэлэн эсэхийг үнэлэх зорилгоор 160 гаруй мянган албан хаагчийг хамруулан 2021 оны 4 дүгээр сард зохион байгууллаа. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг өөрсдийнх нь үнэлгээгээр авахаас гадна, тодорхой эхийг уншуулж, давхар үнэлгээ хийсэн. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 50.9 хувь нь өгөгдсөн эхийн зарим хэсгийг унших чадвартай, 38.8 хувь нь бүтнээр нь унших чадвартай бол 10.3 хувь нь уншиж чадаагүй байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын мэдээллийн санд үндэслэн судалгаанд хамрагдах нийт 159.6 мянган албан хаагчийг тодорхойлж, нууцлалыг хангаж, цахимаар мэдээлэл цуглууллаа. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн төрийн тусгай албан хаагчдыг судалгаанд хамруулаагүй болно.

Уг судалгааг явуулснаар Монгол хэлний тухай хууль болон “Монгол бичгийн үндэсний III хөтөлбөр (2020-2024)”-ийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэх, үндэсний бичгийн талаар төрөөс хэрэгжүүлэх бодлого, үндсэн чиглэл боловсруулахад шаардлагатай тоо, мэдээллийг бий болгосон.

## ЗУРАГ 11. ҮНДЭСНИЙ БИЧГИЙН СУРГАЛТАД ХАМРАГДАХ ХЭРЭГЦЭЭ



Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 85.0 хувь нь үндэсний бичгийн сургалтын хэрэгцээ, шаардлага байгаа гэж хариулжээ. Сургалтад хамрагдах хүсэлтэй төрийн албан хаагчдын 56.1 хувь нь танхимын, 43.1 хувь нь цахим, 0.8 хувь нь бусад хэлбэрийн сургалтад хамрагдах хүсэлтэй байна.



Өрхөд суурилсан мэдээлэл, харилцаа холбооны технологийн судалгаа. Өрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн үйлчилгээний хүртээмж, ашиглалт, 15 ба түүнээс дээш насны иргэдийн компьютер, гар утас, интернэтийн хэрэглээ, мэдээллийн технологийн талаарх мэдлэг, ур чадвар, цахим худалдааны талаарх чанартай статистик тоо мэдээллийг гаргах зорилго Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (хуучин нэрээр)-тай хамтран 2021 оны 11-12 дугаар сард судалгаанд 5297 өрх, 9144 иргэнийг хамруулж зохион байгуулсан.

Судалгаагаар Тогтвортой хөгжлийн зорилго, ОУЦХБ-ын цахим хөгжлийн хэмжүүр, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025”, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхэд шаардлагатай 170 гаруй үзүүлэлтийг бий болгосон.


Судалгааны үр дүнгээс харахад Улаанбаатар хотын өрхийн 44.7 хувь, аймгийн төвийн өрхийн 31.1 хувь, сумын төвийн өрхийн 26.8 хувь, хөдөөгийн багийн өрхийн 11.7 хувь нь тус тус компьютертой байна. Нийт өрхийн 80.0 хувь нь интернэттэй, үүнээс 57.3 хувь нь суурин интернэт, 37.4 хувь нь хөдөлгөөнт өргөн зурвасын интернэт (3G, 4G, USB, modem), 5.3 хувь нь газрын утасгүй өргөн зурвасын интернэтийн үйлчилгээ тус тус хүлээн авч байна.

15 ба түүнээс дээш насны хүн амын 29.9 хувь нь цахимаар бараа, үйлчилгээ худалдан авснаас 55.7 хувь нь хувцас, гутал, спортын бараа, 46.2 хувь нь гэр ахуйн бараа, тавилга, 28.2 хувь нь гоо сайхны бүтээгдэхүүн, үйлчилгээ, 13.9 хувь нь хүнсний бүтээгдэхүүн, хоол захиалга, 10.9 хувь нь техник технологийн бараа, үйлчилгээ авсан байна.



Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. Судалгааны мэдээллийг 2021 онд 11232 өрхөөс цуглуулж, өрхийн сарын дундаж орлого, зарлага, нэг хүнд сард ногдох бодит орлого, хэрэглээний тэнцүү 5 бүлэг, Жини коэффициент, Тейлийн индекс зэрэг үзүүлэлтүүдийг улирал, жилээр тооцож, тархаалаа. Судалгааны 2021 оны 4 дүгээр улирлын дүнгээр өрхийн сарын дундаж нийт орлого, оны үнээр 1.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 218.3 (15.3%) мянган төгрөгөөр нэмэгджээ.


ЗУРАГ 12. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ОРЛОГО, мянган төгрөгөөр



Өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт орлого 2021 оны 4 дүгээр улиралд 1.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 19.0 (1.7%) мянган төгрөгөөр өсжээ. Бодит нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар нэмэгдэхэд тэтгэвэр, тэтгэмжийн бодит орлого 73.1 (28.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлжээ.

Өрхийн сарын дундаж нийт зарлага, оны үнээр 1.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 69.7 (4.8%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

ЗУРАГ 13. НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ НИЙТ ЗАРЛАГА, мянган төгрөгөөр



Нэг өрхийн сарын дундаж (үнийн нөлөөллийг арилган тооцсон) бодит нийт зарлагын хэмжээ 2021 оны 4 дүгээр улиралд 1.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 89.0 (7.6%) мянган төгрөгөөр буурчээ. Бодит нийт зарлагын хэмжээ өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар буурахад хүнсний бус бараа, үйлчилгээний бодит зарлага 72.3 (9.8%) мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.




**Ажиллах хүчний судалгаа.** Судалгааны мэдээллийг 2021 онд 13920 өрхөөс цуглуулж, хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн талаарх мэдээллийг улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд улирал, жилээр тооцож тархаалаа.

Судалгааны 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар ажиллагчид 1.1 саяд хүрч, ажиллах хүчний оролцооны түвшин 58.3 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53.6 хувь, ажилгүйдлийн түвшин 8.1 хувь байна.

**ЗУРАГ 14. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ, улирлаар, мянган хүн**



**ЗУРАГ 15. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, улирлаар**



Хөдөлмөрийн насны хүн амын бүтцийн дээрх өөрчлөлтийн улмаас ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 1.3 нэгж хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 0.9 нэгж хувиар өссөн 53.6 хувьд хүрсэн байна.

Ажиллагчдын тоо 2021 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 2.5 (0.2%) мянган хүнээр өссөн байна.

Ажиллагчдыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 22.1 (13.3%) мянга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынх 8.4 (9.3%) мянгаар буурч, барилгын салбарынх 16.5 (25.6%) мянгаар нэмэгдсэн байна. Харин өмнөх улиралтай харьцуулахад боловсролын салбарт ажиллагчид 12.8 (13.0%) мянгаар, тээврийн салбарынх 9.1 (15.7%) мянгаар өсөж, барилгын салбарынх 12.8 (13.7%) мянгаар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт ажиллагчид 5.8 (30.9%) мянгаар тус тус буурсан байна. Өмнөх улирлаас ажиллагчид буурахад 2021 оны 10 дугаар сараас хилийн боомтуудын үйл ажиллагаа саатсанаар бөөний болон жижиглэн худалдааны бараа бүтээгдэхүүн, барилгын материалын нийлүүлэлт буурсан нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 16. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, улирлаар



**Ургацын алдагдал тооцох туршилтын судалгаа.** Хүн амын хүнсний гол хэрэглээ болох гурил, төмс, хүнсний ногооны хангамж, нөөц, шим тэжээл, ТХЗ-ын 12.3 үзүүлэлт (Хүнсний алдагдлын индекс)-ийг тооцоход ашиглах мэдээллийн эх үүсвэрийг бий болгох, ургац хураалтын дараах үе шатанд ургацын алдагдал, хорогдлын хэмжээг тооцох зорилгоор уг судалгааг анх удаа зохион байгууллаа.

Ургац хураалтын дараах алдагдал/хорогдлын хэмжээг тооцоход хураасан үр тариа, хүнсний ногооны 12.6 хувь нь ургац хураалтын дараах үе шатанд тодорхой шалтгааны улмаас алдагдаж/хорогдсон гэсэн үр дүн гарсан. Ургац хураалтын дараах боловсруулалтын үе шат бүрээр алдагдал/хорогдлыг авч үзэхэд ургац хураах үед 4.1 хувь, бутлах, цайруулах үед 1.4 хувь, хатаалтын үед 1.8 хувь, цэвэрлэх үед 2.8 хувь, тээвэрлэлтийн үед 1.0 хувь, хадгалалтын үед 1.5 хувь байна. Эндээс харахад алдагдал/хорогдол нь ургац хураах, цэвэрлэх үе шатанд хамгийн өндөр хувьтай байна.

**Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд үзүүлж буй коронавирусийн нөлөөллийг судлах панел судалгаа.** Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос цар тахалтай холбоотой авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ ААН-ийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилгоор 2021 оны 1-5, 8 дугаар саруудад зохион байгуулж, үр дүнг тооцож тархаасан.

Судалгаанд 2400 гаруй аж ахуйн нэгж хамрагдсанаас 33.9 хувь нь 2021 оны 6-8 дугаар сард үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадаагүй гэжээ. Улаанбаатар хотод 5 дугаар сараас хатуу хөл хориог цуцалж, ААН-үүдийн үйл ажиллагааг үе шаттай нээсэн нь үйл ажиллагаа хэвийн явуулж байгаа ААН-ийн эзлэх хувь 2021 оны 8 дугаар сард 5 дугаар сараас 12.1 нэгж хувиар өсөхөд нөлөөлжээ.

**ЗУРАГ 17. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, дүнд эзлэх хувиар, судалгаа явагдсан хугацаагаар**



**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс тооцох судалгаа.** 21 аймаг, 112 сум, Улаанбаатар хотод сар бүр зохион байгуулж, үр дүнг тооцож тархаасан. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 12 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 13.4 хувь, өмнөх сараас 2.1 хувиар өссөн байна.


**ХҮСНЭГТ 2. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр**

| Бараа, үйлчилгээний бүлэг                           | 2020.XII   |              | 2021.XII    |              | Өмнөх сараас |              | Жилийн өсөлт |
|---|------------|--------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|
|   | Хувь       | Оролцоо      | Хувь        | Оролцоо      | Хувь         | Оролцоо      | Хувь         |
| <b>Ерөнхий индекс</b>                               | <b>2.3</b> | <b>100.0</b> | <b>13.4</b> | <b>100.0</b> | <b>2.1</b>   | <b>100.0</b> | <b>13.4</b>  |
| Хүнсний бараа, ундаа, ус                            | 2.2        | 96.4         | 5.6         | 41.5         | 0.8          | 40.6         | 20.4         |
| Согтууруулах ундаа, тамхи                           | 0.2        | 7.8          | 0.3         | 2.2          | 0.0          | 1.4          | 6.9          |
| Хувцас, бөс бараа, гутал                            | 0.6        | 26.8         | 1.1         | 8.3          | 0.3          | 15.1         | 6.6          |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш                      | -0.7       | -32.5        | 1.4         | 10.5         | 0.2          | 8.3          | 15.3         |
| Гэр ахуйн тавилга, бараа                            | 0.2        | 6.8          | 0.5         | 3.4          | 0.1          | 4.3          | 9.5          |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ                      | 0.1        | 6.4          | 0.3         | 2.2          | 0.0          | 1.7          | 7.5          |
| Тээвэр  | -0.7       | -31.4        | 2.8         | 20.7         | 0.2          | 11.4         | 21.6         |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ             | 0.0        | 0.2          | 0.1         | 0.6          | 0.0          | 0.2          | 2.4          |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ         | 0.0        | 1.1          | 0.1         | 0.9          | 0.0          | 1.0          | 3.7          |
| Боловсролын үйлчилгээ                               | 0.0        | 0.9          | 0.2         | 1.5          | 0.0          | 0.2          | 3.7          |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 0.2        | 6.6          | 0.6         | 4.3          | 0.2          | 8.6          | 19.0         |
| Бусад бараа, үйлчилгээ                              | 0.2        | 10.9         | 0.5         | 4.0          | 0.1          | 7.1          | 9.6          |



Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 12 дугаар сард улсын хэмжээнд 13.4 хувь гарсны 5.6 нэгж хувь буюу 41.5 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

#### ЗУРАГ 18. ЖИЛИЙН ИНФЛЯЦЫН БҮРЭЛДЭХҮҮН



Жилийн инфляцад бензин, түлшнээс бусад импортын барааны үнэ 4.2 нэгж (30.9%), мах, хатуу түлшнээс бусад дотоодын барааны үнэ 4.0 нэгж (30.0%) хувиар тус тус нөлөөлсөн байна.

**Салбаруудын үйлдвэрлэгчийн үнийн судалгаа.** Аж үйлдвэр, барилга, зочид буудал, нийтийн хоол, мэдээлэл холбоо, тээвэр, дотоод худалдааны салбараар гаргаж, үр дүнг тооцон тархаасан.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ 2021 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 35.0 хувиар өссөн байна. Уул уурхай, олборлолтын дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 41.8 хувиар (нүүрс олборлолтынх 64.5 хувь, газрын тос, олборлолтынх 62.7 хувь, металлын хүдэр олборлолтынх 33.1 хувь, бусад ашигт малтмал олборлолтынх 13.0 хувь) өссөн нь нөлөөлжээ.

**Бичил уурхай эрхлэгчдийн судалгаа.** Уул уурхайн салбарын албан бус секторын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тооцох зорилгоор 3 дахь удаагийн судалгааг 18 аймагт 2021 оны 8-9 сард эхний шатыг, 11-12 дугаар сард хоёрдугаар шатны мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулсан. Судалгаанд нийт 2636 иргэнийг хамруулснаас 81 хувь нь ил уурхай, 19 хувь нь далд уурхайд ажиллаж байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн давхардсан тоогоор 75% нь алт олборлолт эрхэлж байна.

**Малын хагас жилийн түүвэр судалгаа.** Судалгааг 2021 оны 6 дугаар сард улсын хэмжээнд зохион байгууллаа.

Том малын зүй бус хорогдол 14 аймгийн 93 сумын малын индексжүүлсэн даатгалын босго 6 хувийг давсан байна. “Үндэсний давхар даатгал” ХХК нь 28527 малчинтай даатгалын гэрээг байгуулж, 3478 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлжээ. Малчин өрхийн 15.8 хувь нь даатгуулсан бөгөөд өмнөх оноос 0.8 хувиар буурсан байна.

**Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын судалгаа.** Судалгааны мэдээллийг 21 аймаг, 9 дүүргийн 1025 аж ахуйн нэгж, байгууллагаас улирал бүр цуглуулж, үр дүнг ДНБ-ий тооцоонд тусгалаа.

Олон үзүүлэлтийн бүлгийн түүвэр судалгаа<sup>нэмэх</sup>. Хүүхэд, гэр бүл, өрхийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг бий болгох зорилгоор НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран судалгааны III-VI шатны мэдээллийг 2200 өрхөөс ярилцлагыг утсаар авах арга (CATI)-аар цуглуулж, үр дүнг тооцож, тархаалаа. Судалгааны III шатанд хүүхэд хамгаалал, хүүхдийн зайн сургалт, IV шатанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, 0-4 насны хүүхдийн сайн сайхан байдал, эрүүл мэнд, V шатанд өсвөр насныхны эрүүл мэнд, сайн сайхан байдал, уур амьсгалын өөрчлөлт, амьдралын сэтгэл ханамж, VI шатанд Ковид-19 цар тахлын үе дэх 2-17 насны хүүхдүүдийн зайн сургалтын талаарх мэдээлэлт, нэмэлтээр судалгааны бүх шатанд Ковид-19 халдвараас өөрийгөө хамгаалах дадал, халдвартай холбоотой санаа зовнил, шинжилгээнд хамрагдсан байдал, вакцинжуулалт болон хүүхэдтэй холбоотой мэдээллийг цуглуулав. Судалгааны мэдээлэл цуглуулалтад 2 багийн ахлагч, 11 судлаач ажилласан.




Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа. Коронавирусийн өрхөд үзүүлж буй нөлөөг цаг тухайд нь хянах зорилгоор Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банктай хамтран 2021 онд судалгааны IV, V шатны мэдээлэл цуглуулалтыг утсаар зохион байгуулж, III, IV, V шатны үр дүнг тооцож, тархаасан. Судалгааны V шатны үр дүнг Улаанбаатар, аймгийн төв, сумын төв, хөдөөг төлөөлөх чадвартай 1046 өрхийн мэдээлэлд үндэслэн тооцсон.

Судалгааны V шатны үр дүнгээр цар тахлаас өмнө ажил эрхэлж байсан эмэгтэйчүүдийн 42 хувь, эрэгтэйчүүдийн 27 хувь нь хөдөлмөр эрхлэхээ больсон бөгөөд эмэгтэйчүүдийн 22 хувь, эрэгтэйчүүдийн 7 хувь нь гэртээ хүүхдээ асрах шаардлага гарсан гэж тайлбарласан байна.



Засгийн газраас 2021 оны 4 дүгээр сард олгосон нэг удаагийн мөнгөн тусламжийн дараа Засгийн газраас хүлээн авсан дундаж шилжүүлгийн хэмжээ III шатны судалгааны үеийнхтэй ижил түвшинд очсон байна. Мөнгөн тусламжийн хэмжээ буурсан ч ядуу өрхүүдийн Засгийн газраас хүлээн авч буй дундаж мөнгөн тусламжийн хэмжээ (318 мянган төгрөг) цар тахлын өмнөх буюу 2018 оны ядуу өрхүүдийн орлогын хагастай тэнцсэн байна.

#### ЗУРАГ 20. СҮҮЛИЙН 30 ХОНОГТ ЗАСГИЙН ГАЗРААС ХҮЛЭЭН АВСАН ДУНДАЖ ШИЛЖҮҮЛГИЙН ХЭМЖЭЭ



**Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал, өрхийн панел судалгаа.** ХБНГУ-ын Боловсрол судалгааны яам, Цаг уурын хүрээлэнтэй хамтран баруун аймгуудын өрхийн аж байдалд ган, үер, зуд зэрэг цаг уурын эрсдэлт үзэгдлүүд хэрхэн нөлөөлдөг, өрхүүд ган, зуд болон бусад таагүй үйл явдлыг даван туулахын тулд ямар арга хэмжээ авдаг, эдгээр таагүй үйл явдлууд өрхөд үзүүлэх үр дагаврын талаар мэдээлэл бий болгох, шинжилгээ хийх зорилгоор явуулсан. Судалгаанд төслийн 2 ажилтан, 9 судлаач, 3 жолооч, нийт 14 ажилтан ажилласан.

Судалгааны IV шатны үр дүнг боловсруулж, тархааж, V шатны мэдээллийг цуглуулж эхэллээ. Төслийн хүрээнд “Бэлэн мөнгө” хөтөлбөр хэрэгжүүлж, малчин өрхүүдэд 250.0 сая төгрөгийн тусламж үзүүлсэн.

**Жендэр ба хүрээлэн буй орчин.** НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтран жендэр ба хүрээлэн буй орчны талаарх үндэсний хэмжээний суурь судалгаатай болох, хүрээлэн буй орчин, гамшгийн нөлөөллийн зарим мэдээллийг хүйсээр ангилж гаргах зорилгоор уг судалгааг 2021 оны 8 дугаар сард улсын хэмжээнд зохион байгуулсан. Судалгаанд 5 багийн ахлагч, 30 судлаач ажиллаж, утсаар ярилцлага хийх аргаар судалгааны мэдээллийг цуглуулсан.

**Малчдын аж байдал ба жендэр судалгаа.** НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтран Малчдын аж байдал ба жендэр туршилтын судалгааг Булган аймагт зохион байгуулж, Судалгаанд 5 судлаач ажиллаж, 50 өрхөөс мэдээллийг цуглуулж, мэдээллийг баазыг шалгаж, холбогдох байгууллагад хүргүүлэв.

**Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн хөтөлбөр.** Дэлхийн улс орнуудын үндэсний тооцооны мэдээллийг нэгтгэх, харьцуулалт хийх, олон улсын түвшинд болон худалдан авах чадварын паритетыг тооцох зорилгоор АХБ-ны дэмжлэгтэйгээр 2021 оны хөтөлбөрийг хэрэгжүүлж, Өрхийн хэрэглээний барааны, орон сууцны түрээсийн, барилгын материалын, машин, тоног төхөөрөмжийн үнийн судалгааны мэдээллийг цуглуулж, баталгаажууллаа. Мөн Барилгын материал, орон сууцны түрээсийн үнийн судалгааны каталогийг боловсрууллаа.

**Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа.** НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Баянхонгор, Завхан, Говь-Алтай аймагт зохион байгуулж, үр дүнг тооцон, тайланг НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн.

Монголбанктай хамтран 2021 онд Аж ахуйн нэгжийн үнийн хүлээлтийн судалгаа, Иргэдийн инфляцын хүлээлтийн судалгаа, Худалдан авалтын менежерийн судалгаа, Бизнесийн түүвэр судалгааг улирал тутам зохион байгууллаа.

## 1.4 ТООЦОО, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ

**Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцооны суурь шинэчлэлт.** 2015 оны суурь нөөц, ашиглалтын хүснэгтийг байгуулж, ДНБ-ий суурь оныг шинэчилж, үр дүнгээр 2016-2019 жилийн нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийг, үндэсний тооцооны 2015-2021 оны үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцож, нийтэд мэдээллээ. Дараах аргачлал, ангилал, судалгаа, тооцооллын үр дүнг суурь шинэчлэх ажлын хүрээнд тусгалаа. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарын малын ашиг шимийн бүтээгдэхүүний гарцын судалгаа,
- Үйлдвэрлэгчийн үнийн судалгаанууд,
- ХАА-н үйл ажиллагаа эрхэлдэг нэгжийн үйл ажиллагааны зардлын судалгаа,
- Далд эдийн засгийн судалгаа,
- ААНБ-ын өртөг, зардлын түүвэр судалгаа зэрэг суурь судалгаа
- “Үндэсний тооцооны систем-2008”-ын хүрээнд Шууд бусаар хэмжих санхүүгийн байгууллагын үйлчилгээний арга зүйг банкны салбарын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртгийн тооцоонд нэвтрүүлсэн.
- Төлбөрийн тэнцлийг боловсруулах BPM-6 арга зүйг Төлбөрийн тэнцлийн тооцоололд тусгасан.
- Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, Бүтээгдэхүүний нэгдсэн ангилал, Эдийн засгийн ерөнхий ангиллыг шинэчлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.

**ЗУРАГ 21. ДНБ-ИЙ ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР**

Эдийн засгийн бодит өсөлт 2020 онд 2010 оны зэрэгцүүлэх үнээр 5.3 хувиар буурч байсан бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр 4.5 хувиар буурсан дүн гарлаа.



**Нийгмийн тооцооны матриц.** Эдийн засгийн бүтцийг харуулах нийгмийн тооцооны матрицыг 2015-2020 оны гүйцэтгэлээр байгууллаа. Нөөц, ашиглалтын хүснэгтийг үндэсний тооцооны дансуудаар өргөтгөснөөр эдийн засаг дахь орлого, татвар, төлбөр, шилжүүлэг зэрэг гүйлгээний бүх урсгалыг эдийн засгийн сектор, хүчин зүйлсийн орлогоор харуулснаар үндэсний тооцооны системийн мэдээллийг нэгтгэн, уялдаа холбоо, харилцан хамаарлыг судлах, мэдээллийн чанарыг сайжруулах, нийгэм, эдийн засгийн бодлогын шинжилгээг хийх боломжийг бүрдүүлж байна.

**ХҮСНЭГТ 3. НИЙГМИЙН ТООЦООНЫ МАКРО МАТРИЦ, 2020 он**

| ДАНС               | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн  | Хүчин зүйлс   | Өрхийн аж ахуй | ААНБ          | Засгийн газар | Хөрөнгө оруулалт | Гадаад эдийн засаг | Бүгд   |
|--------------------|---------------|---------------|---------------|----------------|---------------|---------------|------------------|--------------------|--------|
| Үйл ажиллагаа      |               | 73 773        |               |                |               |               |                  |                    | 73 773 |
| Бүтээгдэхүүн       | 39 876        |               |               | 22 649         |               | 5 922         | 7 954            | 21 596             | 97 995 |
| Хүчин зүйлс        | 33 752        |               |               |                |               |               |                  | 960                | 34 712 |
| Өрхийн аж ахуй     |               |               | 20 727        | 122            | 1 457         | 4 482         |                  | 530                | 27 317 |
| ААНБ               |               |               | 9 189         | 1 540          | 4 033         | 322           |                  |                    | 15 083 |
| Засгийн газар      | 146           | 3 556         | 1 067         | 2 446          | 2 593         | 175           |                  | 249                | 10 231 |
| Хадгаламж          |               |               |               | 561            | 7 001         | -1 454        |                  | 1 846              | 7 954  |
| Гадаад эдийн засаг |               | 20 666        | 3 729         |                |               | 785           |                  |                    | 25 180 |
| <b>Бүгд</b>        | <b>73 773</b> | <b>97 995</b> | <b>34 712</b> | <b>27 317</b>  | <b>15 083</b> | <b>10 231</b> | <b>7 954</b>     | <b>25 180</b>      |        |


**Байгаль орчин, эдийн засгийн дансны систем.** БОЭЗДС-ийн хүрээний дараах дансуудыг байгууллаа. Үүнд:

1. Хатуу хог хаягдлын биет урсгалын дансыг 2018-2019 оны гүйцэтгэлээр (туршилтаар),
2. Усны биет урсгалын дансыг 2018-2019 оны гүйцэтгэлээр (туршилтаар),
3. Байгаль орчны татварын дансыг 2020 оны гүйцэтгэлээр,
4. Байгаль орчныг хамгаалах зардлын дансыг 2020 он
5. Агаар дахь ялгаруулалтын дансыг 2020 оны гүйцэтгэлээр,
6. Материал урсгалын дансыг 2020 оны гүйцэтгэлээр,
7. Эрчим хүчний биет урсгалын дансыг 2020 оноор.

**Хүн амын 2020-2050 оны шинэчилсэн хэтийн тооцоо.** Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнгээр хүн амын хэтийн тооцоог 2020-2050 оноор шинэчилснээр хүн амын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж, судалгаа, шинжилгээний суурь мэдээллийг бүрдүүлснээр хүн ам, нийгэм, эдийн засгийн бодлого, төлөвлөлт, салбаруудын ирээдүйн эрэлт, хэрэгцээг тооцох боломжтой боллоо. Тухайлбал, хүн амын ердийн хөдөлгөөний өөрчлөлт болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний өнгөрсөн хугацааны тоон мэдээлэлд шинжилгээ хийж, цаашдын төлөвийг тодорхойлсон нь хэрэглэгчдэд ирээдүйн хүн амын тоо, өсөлт, нас, хүйсийн бүтэц, байршлын талаар төсөөлөл өгч, бодлого, хөтөлбөрийг тодотгох, уялдуулах боломжийг олгож байна.

Хүн амын тоог хэд хэдэн хувилбараар тооцсон бөгөөд “1Б” хувилбараар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн ам 2050 онд 5.0 саяд хүрэхээр байгаа бол Монгол Улсын харьяат хүн амаар тооцсон “2Б” хувилбараар 2048 онд 5.0 саяд, 2050 онд 5.2 саяд хүрэхээр байна.

**ЗУРАГ 22. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ, дундаж бууралттай хувилбараар, 2020-2050 он**



Хүн ам 1 саяар нэмэгдэх хугацаа харилцан адилгүй байна. Тухайлбал, 1962 оноос 1988 он хүртэл 26 жил байсан бол 1988 оноос 2015 он хүртэл 27 жил, 2015 оноос 2033 хүртэл 18 жилийн хугацаанд Монгол Улсын харьяат хүн ам 4 саяд хүрэхээр байна.

Монгол Улсын харьяат хүн амаар тооцсон "2Б" хувилбараар нийт хүн амд 0-14 насны хүүхдүүдийн эзлэх хувийн жин 2020 онд 31.7 байсан бол 2050 онд 27.4 болох төлөвтэй байна. Нийт хүн амд 65 ба түүнээс дээш насныхны эзлэх хувь 2020 онд 4.2 хувь байсан бол 2050 онд 12.0 хувь болж, 3 дахин нэмэгдэхээр байна.

Хүн ам зүйн ачаалал 2020 онд 55.9 байсан бол 2050 онд 65.0 болж нэмэгдэж, хүүхдийн ачаалал буурч, хөгшдийн ачаалал өсөхөөр байна. Голч нас 2020 онд 27.9 буюу "идэр" насны бүтэцтэй байсан бол 2050 онд голч нас нэмэгдэн 30.6 болж "хөгшин" насны бүтэцтэй болохоор байна.

**ХҮСНЭГТ 4. ХҮН АМЫН НАСНЫ БҮТЦИЙН ЗАРИМ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2020-2050 он**

| Он   | Голч нас | Хөгшрөлтийн индекс | Хүн ам зүйн ачаалал |        |        |
|------|----------|--------------------|---------------------|--------|--------|
|      |          |                    | Нийт                | Хүүхэд | Хөгшид |
| 2020 | 27.9     | 13.2               | 55.9                | 49.4   | 6.5    |
| 2025 | 28.3     | 16.5               | 58.7                | 50.4   | 8.3    |
| 2030 | 28.2     | 22.9               | 56.1                | 45.6   | 10.5   |
| 2035 | 28.0     | 29.6               | 54.9                | 42.4   | 12.5   |
| 2040 | 28.7     | 35.7               | 56.3                | 41.5   | 14.8   |
| 2045 | 29.8     | 39.9               | 60.7                | 43.3   | 17.3   |
| 2050 | 30.6     | 44.0               | 65.0                | 45.1   | 19.9   |

Хэтийн тооцооллоор 100 эмэгтэй хүн амд ногдох эрэгтэйчүүдийн тоогоор илэрхийлэгддэг хүйсийн харьцаа нь 2020 онд 96.5 хувь байснаа 2050 онд 96.9 хувь болж тогтвортой байхаар байна.

Төрөлтийн ерөнхий коэффициент 2020 онд 23.4 байсан бол 2030 онд 19.35 болж буурч, 2040 онд 20.84 болж аажим өсөхөөр харагдаж байна. Харин нас баралтын ерөнхий коэффициент 2020 онд 5.1 байснаа 2050 онд 6.34 болж, нас баралтын түвшин нэмэгдэхээр байна.



**Хүн амын боловсролын 2020-2050 оны хэтийн тооцоо.** Боловсролын үйлчилгээний өнгөрсөн болон өнөөгийн хангамж, хүртээмжийн мэдээлэлд үндэслэн ирээдүйн эрэлт, хэрэгцээг тодорхойлж, боловсролын салбарын 15 суурь үзүүлэлтийн хэтийн тооцоог боловсруулсан.

Сургуулийн өмнөх боловсролын насны хүүхдийн тоо 2020 онд 316.4 мянга байсан бол 2025 онд 294.2 мянга, 2035 онд 289.5 мянга, 2045 онд 370.4 мянга, 2050 онд 387.4 мянга, ерөнхий боловсролын сургуулийн 1-р ангид шинээр элсэгчдийн тоо 2020 онд 78.2 мянга байсан бол 2025 онд 72.7 мянга, 2035 онд 68.1 мянга, 2045 онд 85.8 мянга, 2050 онд 93.1 мянга болох төлөвтэй байна.

**Ядуурлын тооцоо.** Дэлхийн банктэй хамтран ядуурлын 2020 оны тооцоог үр шинэчиллээ. Бүх нийтийг хамарсан цар тахлын нөлөө өндөр байсан үед хүн амын хэрэглээ, ядуурлыг тооцоход хүндрэл үүссэн учраас өмнөх ядуурлын тооцоотой харьцуулагдахуйц, тасралтгүй байдлыг хангахын тулд өрхийн хэрэглээг тайлбарлаж чадахуйц үзүүлэлтүүдийг сонгон үнэлж, олон удаагийн орлуулга хийх (SWIFT+) аргыг ашиглаж ядуурлын 2020 оны тооцоог хийсэн.

Уг аргачлалын дагуу 2018 оны ӨНЭЗС-ны мэдээллийн сан дээр хэрэглээг орлуулан тооцох тохиромжтой хэрэглээний загварыг боловсруулж, 2020 оны ӨНЭЗС-ны мэдээллийн санд үндэслэж, ядуурлыг тооцсон.



Хүн амын ядуурлын түвшин 2018 онд 28.4 хувь байсан бол 2020 онд 27.8 хувь болж 0.6 нэгж хувиар буурсан байна. Хөдөө орон нутагт ядуурлын түвшин хот суурин газраас өндөр хэвээр байгаа ч нийт ядуу хүн амын гуравны хоёроос илүү нь хот суурин газарт үүнээс 43 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.

**ЗУРАГ 23. ЯДУУРЛЫН ТҮВШИН**




**ЗУРАГ 24. ЯДУУ ХҮН АМЫН ТАРХАЛТ, СУУРЬШЛААР**



**Судалгаа, шинжилгээ.** ҮСХ-ноос тооллого, судалгааны мэдээлэл, албан ёсны болон захиргааны статистикийн мэдээг боловсруулан эдийн засаг, нийгмийн үзүүлэлтээр судалгаа, шинжилгээний 12 ажил, ДНБ, хөдөлмөрийн бүтээмжийн 2020, 2021 оны жил, улирлын гүйцэтгэлээрх танилцуулга, ДНБ-ий жил, улирлын дэлгэрэнгүй танилцуулга, Хүн ам, Хөдөлмөр, Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухаан, Хөдөө аж ахуй, Аж үйлдвэр, Инфляц, үнийн өөрчлөлт зэрэг 28 салбарын танилцуулгыг бэлтгэж, тархаасан (Хавсралт 4).

**Хөдөө аж ахуйн статистикийн мэдээлэлд алсын зайнаас тандан судлах арга зүй.** Машин сургалтын Random Forest алгоритмыг ашиглан Төв аймгийн Жаргалант сумын тариалангийн талбайг ургацын төрлөөр нь зураглахад судалгааны талбайд өгөгдсөн өгөгдлийг ашиглан буудай, рапс, төмс гэсэн 3 төрлийн таримлыг тодорхойлсон. Уг алгоритмаар ерөнхий ажлын нарийвчлал нь 76.92 хувь, каппа коэффициент нь 63.2 хувьтай гарсан. Тандалт судалгааны үр дүнгээр Машин сургалтын аргаар ургац хураалтыг тооцох арга зүйн суурийг бий болголоо.

**ЗУРАГ 25. ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН АНГИЛСАН ЗУРАГ**



**Салбар хоорондын тэнцлийн шинжилгээ.** Салбар хоорондын тэнцэл, нөөц, ашиглалтын хүснэгтийн талаарх ойлголтыг судлаач, бодлого боловсруулагч нарт таниулах зорилгоор салбар хоорондын тэнцлийн аргагүй, нэр томъёоны тайлбар болон ямар зориулалтаар ашиглаж болохыг судалж жишээ болгон эдийн засгийн төрөлжилт, Засгийн газрын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нөлөө, гол нэрийн бараа бүтээгдэхүүн, цалингийн өсөлтийн салбаруудын үнэд үзүүлэх нөлөө зэргийг тооцооллоо. Мөн хамгийн өндөр хөрөнгө оруулалт бүхий 5 салбарыг сонгон тус салбарт төслүүдийг хэрэгжүүлсэн тохиолдолд гарах нөлөөллийг Леонтьевийн орцын урвуу матрицийг ашиглан тухайн хөрөнгө оруулалтаас шалтгаалан нийт үйлдвэрлэл, үүнд тухайн салбарын өөрийн үйлдвэрлэл болон бусад орцоор хангах салбаруудын өсөлтөд ямар нөлөө үзүүлэхийг ялгаж тооцлоо.


Шинжилгээний үр дүнгээс харахад газрын тос боловсруулах болон төмөр замын төслийн нийт үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө бусад том төслүүдтэй харьцуулахад хамгийн өндөр бол дулааны цахилгаан станцын төслийн хувьд бусад салбарын үйлдвэрлэлийг дэмжих нөлөө их байна.

**ХҮСНЭГТ 5. СОНГОСОН ТӨСЛҮҮДИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ, ҮЙЛДВЭРЛЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**

| Төсөл  | Төлөөлөх салбар                              | Хөрөнгө оруулалт |               | Нийт үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө | Өсөлтийн задаргаа |              |
|--|--|------------------|---------------|--------------------------------|-------------------|--------------|
|  |  | 2021-2025        | Жилийн дундаж |                                | Тухайн салбар     | Бусад салбар |
| Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах                                | Газрын тос, химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл | 3 316            | 663           | 2.8%                           | 2.0%              | 0.8%         |
| Тавантолгой Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын төсөл                | Барилга                                      | 2 809            | 562           | 2.7%                           | 1.7%              | 1.0%         |
| Цагаансуваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах төсөл           | Металлын хүдэр олборлолт                     | 2 214            | 443           | 1.8%                           | 1.3%              | 0.5%         |
| Багануурын дулааны цахилгаан станц төсөл                                 | Цахилгаан, хий, уур, агааржуулалт            | 2 183            | 437           | 2.5%                           | 1.3%              | 1.2%         |
| Улаанбаатар хотын ус хангамжийг урт хугацаанд тогтвортойгоор нэмэгдүүлэх | Ус хангамж, ус зайлуулах систем              | 1 311            | 262           | 1.2%                           | 0.8%              | 0.5%         |

Дээд боловсрол эзэмшигчдийн мэргэжил ба хөдөлмөр эрхлэлтийн хамаарлын судалгаа. Энэхүү судалгаагаар ХАӨМС, Боловсролын мэдээллийн сан, Нийгмийн даатгалын сангуудын өгөгдлийг уялдуулан дээд боловсрол эзэмшсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдлыг судлахыг зорьсон. Эзэмшсэн мэргэжил нь хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөг олон гишүүнт логистик регрессийн загвар ашиглан тооцоолов. Судалгааны үр дүнгээр мэргэжлийн чиглэлээс хамааран хөдөлмөр эрхлэлтийн түвшин хүн амын дунд ялгаатай байгаа нь ажиглагдлаа.

ЗУРАГ 26. ИХ ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, мэргэжлийн чиглэлээр, 2013-2020, хувиар



Мэргэжил ба хөдөлмөр эрхлэлтийн хамаарлын судалгаа. Уг судалгаагаар ХАӨМС, Боловсролын мэдээллийн сан, Нийгмийн даатгалын сангуудын өгөгдлийг уялдуулан дээд боловсрол эзэмшсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдлыг нарийвчлан судлах зорилгоор эзэмшсэн мэргэжил нь хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй нөлөөлийг олон гишүүнт логистик регрессийн загвар ашиглан тооцоолов.

Сангуудын уялдуулсан энэхүү өгөгдлийн хувьд их дээд сургууль төгсөгчдийн 79.6 хувь нь ажилтай, 1.5 хувь нь ажил хайж байгаа 18.9 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоонд орж байна. Харин дээд боловсрол эзэмшээгүй иргэдийн 45.7 хувь нь ажилтай, 3.7 хувь нь ажилгүй 50.6 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

Хувийн их, дээд сургууль төгссөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 78.5 хувь, Улсын их, дээд сургууль төгссөн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 80.9 хувь байна. Дээд боловсрол эзэмшээд хотод амьдарч буй иргэдийн хөдөлмөр эрхлэлт 79.4 хувь, хөдөө амьдарч буй иргэдийн хөдөлмөр эрхлэлт 80.6 хувь байна.

Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр төгсөгчид (70.6 хувь) болон нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр төгсөгчид (75.3 хувь) нь бусад мэргэжлийн чиглэлтэй харьцуулахад бага хөдөлмөр эрхлэлттэй нь байна. Харин үйлчилгээний чиглэлийн мэргэжилтэй төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр (87.1 хувь) байна.

**ХҮСНЭГТ 6. ИХ ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, 2021 ОНЫ БАЙДЛААР, МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР, дүнд эзлэх хувиар**

| Ерөнхий ангилал                   | Ажил эрхлэлтийн шинж байдал |           |            |        |
|-----------------------------------|-----------------------------|-----------|------------|--------|
|                                   | Ажилтай %                   | Ажилгүй % | Идэвхгүй % | Нийт % |
| Боловсрол (n=13,183)              | 83.08                       | 2.53      | 14.39      | 100.00 |
| Урлаг, хүмүүнлэг (n=8,799)        | 70.12                       | 2.01      | 27.87      | 100.00 |
| Нийгмийн шинжлэх ухаан (n=5,285)  | 76.05                       | 2.04      | 21.91      | 100.00 |
| Бизнес удирдлага (n=33,383)       | 79.24                       | 1.82      | 18.94      | 100.00 |
| Байгалийн шинжлэх ухаан (n=3,065) | 79.90                       | 1.96      | 18.14      | 100.00 |
| Мэдээлэл харилцаа (n=3,778)       | 79.59                       | 1.69      | 18.71      | 100.00 |
| Инженерчлэл, үйлдвэрлэл (n=9,280) | 82.47                       | 1.66      | 15.87      | 100.00 |
| Хөдөө аж ахуй (n=3,235)           | 79.66                       | 2.69      | 17.65      | 100.00 |
| Эрүүл мэнд (n=11,469)             | 84.86                       | 1.12      | 14.02      | 100.00 |
| Үйлчилгээ (n=4,581)               | 88.67                       | 1.27      | 10.06      | 100.00 |
| Нийт (n=96,058)                   | 80.21                       | 1.85      | 17.91      | 100.00 |

## 1.5 МЭДЭЭЛЭЛ ТАРХААЛТ

ҮСХ нь статистик мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэхээс гадна хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, мэдээллийг хүртээмжтэй, ойлгомжтой хэлбэрээр тархаахад анхаарч ажиллаж байна. Хэрэглэгчдийн байнга өсөн нэмэгдэж буй хэрэгцээнд нийцүүлэн статистикийн өгөгдөл, үзүүлэлтийг тогтмол баяжуулж, мэдээлэл тархаах арга, хэлбэрийг шинэчлэн сайжруулсаар ирсэн. Тухайлбал:

- Статистикийн мэдээлэгч, хэрэглэгчдэд үйл ажиллагаагаа сурталчлах, бүтээгдэхүүний өнгө үзэмж, загварыг сайжруулах зорилгоор байгууллагын брэнд номыг шинэчлэн мөрдөж байна.
- Хэрэглэгчид мэдээллийг авахад хялбар, ойлгомжтой болгох зорилгоор Статистикийн мэдээллийн нэгдсэн сан болон ҮСХ-ны албан ёсны цахим хуудсыг нэгтгэн, хайлтын систем, мэдээллийн сан, үндсэн сайтыг нэгтгэж, хэрэглэгчид зориулсан талбар, хэрэглэгчид сонголт, туршлагад суурилсан (UI/UX) платформыг нэвтрүүлж байна.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (1212.mn)-ийн бүтцийг шинэчилж, Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдал, Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын нэгдсэн дүн, Хүн ам, Гэр бүл, хүүхэд, залуучууд, Жендэрийн үзүүлэлтээр хянах самбар бэлтгэн байршууллаа.
- Эдийн засгийн салбарын 34 ААНБ-ын төлөөлөл оролцсон “Статистикийн мэдээллийн хэрэглээ, ач холбогдол” сэдэвт уулзалт зохион байгуулж, статистикийн үйл ажиллагааны шинэчлэл, төрийн их өгөгдөл, эдийн засгийн салбарын статистикийн мэдээллийн хэрэглээ, ач холбогдол сэдвээр мэдээлэл солилцсон.
- Статистикийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Мэргэжилтнээс сонсьё”, “Бидний бахархал”, “Сонирхолтой статистик” болон түүхэн контентуудыг 2021 онд шинээр бэлтгэж, хэрэглэгчдэд хүргэсэн бөгөөд 1212.mn цахим хуудасны хандалт 1.5 саяд хүрч, өмнөх оныхоос 19.2 хувь,

nso.mn сайтын хандалт 337.4 мянга болж, 49.9 хувь, фэйсбүүк хуудасны хандалт 3.5 саяд хүрч, 15.3 хувиар тус тус өссөн байна.

## ЗУРАГ 27. СТАТИСТИКИЙН ЦАХИМ ХУУДАСНЫ ХАНДАЛТ



Монгол Улсын нийгэм, эдийн засгийн сарын 24 танилцуулга, Статистикийн жилийн эмхэтгэл, 15 аймгийн Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүн, тооллогын үр дүнгээрх 13 сэдэвчилсэн судалгаа, 25 судалгааны үр дүн, Монгол Улс 100 жилд эмхэтгэл, ном, сэтгүүл, инфографик нийт 171 материалыг цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулж, тархаасан.


Олон улсын валютын сангийн мэдээлэл тархаалтын тусгай стандартын дагуу нийгэм, эдийн засгийн 22 салбарын мэдээллийг Статистикийн мэдээлэл, мета мэдээллийг солилцох стандарт (SDMX)-д хөрвүүлэн, сар бүр шинэчилж байна.

Монгол Улсын урт хугацааны “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх үндсэн 73 үзүүлэлтийн 2020 оны тоон мэдээллийг холбогдох 17 төрийн байгууллагаас авч нэгтгэн, ТХЗ-ын хэрэгжилтийг хянах нэгдсэн системийг баяжууллаа.

ЗГХЭГ-ын хүсэлтээр “Алсын хараа-2050” бодлогын хэрэгжилтийн явцыг хянах дашбоардыг байгуулж, <https://2050.gov.mn> домэйн хаяг дээр байршуулж тархаасан.

ҮСХ нь НҮБ-ын Статистикийн комиссоос Дата сэтгүүл зүйг статистикийн байгууллагууд дэмжиж ажиллахыг зөвлөмж болгосны дагуу сэтгүүлчдийн уулзалтыг 2 удаа зохион байгуулж, “Төрийн их өгөгдөл”, “ҮСХ-ны үйл ажиллагааны шинэчлэл” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүллээ. Цаашид сэтгүүлчдийг сургах, дата сэтгүүл зүйг дэмжсэн, хэрэглэгчдэд чиглэсэн үйл ажиллагааг өргөтгөх зорилт тавьж ажиллаж байна.

ЗУРАГ 28. ШИНЭЧИЛСЭН ЦАХИМ ХУУДАСНЫ ЗАГВАР




# ХОЁР. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 2.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Статистикийн тухай хуульд заасан ҮСХ-ны бүрэн эрхийг хэрэгжүүлэх, албан ёсны статистикийн шинэчлэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээлэл, өгөгдлийн байнга өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагыг хангах зорилготой 8 газар, 16 хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 29. ҮСХ-НЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ҮСХ-ны дотоод бүтцэд өгөгдлийн засаглал, өгөгдлийн шинжилгээг хөгжүүлэх үүрэг бүхий нэгжийг шинээр бий болголоо. Мөн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор ПАРИС21 байгууллагын санхүүжилтээр зөвлөх үйлчилгээ авч ажиллаж байна.

Уялдаа холбоотой, чанарын шаардлагыг хангасан мэдээлэлд үндэслэн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нарийвчилсан салбар хоорондын үзүүлэлтүүдийг бэлэн болгох, төсвийн зардал хэмнэх, мэдээлэгчид очих ачаалал, давхардлыг бууруулах, хэрэглэгчдэд мэдээлэл шуурхай хүргэх “Төрийн их өгөгдөл” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлэв. Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулах зорилгоор ЭМЯ, ХНХЯ, ЗТХЯ, ХХААХҮЯ, БХБЯ, ШЕЗ зэрэг 11 яам, төрийн үйл ажиллагаатай танилцаж, цаашид хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг УИХ-ын ЭЗБХ-нд тайлагнаж, салбарын дунд хугацааны зорилго, зорилтыг тодорхойлж, статистикийн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүний нөөцийн хөгжлийг хангах, дэд бүтцийг сайжруулах, статистикийн мэдээлэл

эрхлэн гаргах ажиллагааг боловсронгуй болгох зорилтыг агуулсан “Статистикийн салбарын 2021-2025 оны стратегийн төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна.

ҮСХ-ны Зөвлөлийн хурлыг зохион байгуулж, 2020 оны үйл ажиллагааны тайлан, Статистикийн салбарыг 2021-2025 онд хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн төслийг танилцуулсан. Даргын зөвлөлийн хурлыг 22 удаа зохион байгуулж, 33 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 12 асуудалтай танилцсан байна.


## ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ

Статистикийн тухай хуульд заасны дагуу ҮСХ нь Нийслэлийн статистикийн газар, дүүрэг, аймагт статистикийн хэлтэстэйгээр нийт 320 орон тоотой ажиллаж байна. Үүнээс ҮСХ-нд 122, 21 аймгийн статистикийн хэлтэст 129, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэст 69 албан хаагч ажиллаж байна.

ЗУРАГ 30. САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР



ЗУРАГ 31. САЛБАРЫН АЛБАН ХААГЧИД, АЖИЛЛАСАН ЖИЛЭЭР



Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу салбарын 122 төрийн албан хаагчид зэрэг дэв, 47 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинээр олгуулж, 11 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлт, 27 албан хаагчдад буцалтгүй тусламж олгосон. Салбарын албан хаагчдын амьдрах орчин, нөхцөлийн судалгааг гаргаж, 11 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлт, 27 албан хаагчдад буцалтгүй тусламж олгосон.

Салбарын хэмжээнд 79 албан хаагч чөлөөлөгдсөнөөс, жирэмсний болон амаржсаны чөлөө 11 албан хаагч авсан. Шинээр 49 албан хаагчийг томилогдож, 22 албан хаагчийн албан тушаал өөрчлөгдөн, дэвшсэн.



## ЗУРАГ 32. САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨДӨЛГӨӨН



Салбарын албан хаагчдад чиглэсэн хувь хүний хөгжил, манлайлал, статистик үзүүлэлтийн арга зүй, аргачлал, сургагч багш бэлтгэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 1400 гаруй албан хаагчийг хамрууллаа (Хавсралт 5). Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан 84 цахим сургалт, арга хэмжээнд давхардсан тоогоор 243 албан хаагч оролцож, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн.

### 2.2. АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН ШИНЭЧЛЭЛ

**Байгууллагын бүтэц зохион байгуулалт.** НҮБ-ын Статистикийн комиссоос зөвлөмж болгосны дагуу албан ёсны статистикийн шинэчлэлийн хүрээнд дэлхийн 50 гаруй статистикийн байгууллага статистикийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, баримтжуулахад Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-ыг нэвтрүүлж байна. ҮСХ нь Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (CYAE3)<sup>1</sup>-ыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг 2017 оноос эхлүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлж, 2021 онд статистикийн байгууллагуудын үйл ажиллагааны ерөнхий загвар (GAMSO)-ын гарын авлагын 1.2 хувилбарын төслийг боловсруулж, байгууллагын төлөвшлийн түвшнээ тодорхойлох, ялгаатай байдлын дүн шинжилгээг хийлээ.

ҮСХ-ны цуглуулсан өгөгдөл, мэдээллийн урсгалыг зохион байгуулах, өгөгдөл боловсруулах уламжлалт аргыг шинэ түвшинд гаргасан, программ хангамж, өгөгдлийн шинжилгээг хослуулан албан ёсны статистикийн шинэчлэлийн стандарт загварт нийцүүлэн хөгжүүлсэн “Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн SPS систем”-ийг ашиглаж эхэлсэн. Ингэснээр статистикийн өгөгдлийг өрх, аж ахуйн нэгжээс цуглуулахаас эхлээд Статистикийн нэгдсэн мэдээллийн сан ([www.1212.mn](http://www.1212.mn)) цахим хуудаст нийтэд хүртээл болгох хүртэл бүх дамжлагыг автоматжуулан, хүний оролцоог багасгалаа.

Статистикийн үйл ажиллагааг цахимжуулах, цар тахлын үед мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагааг хэвийн явуулах арга хэмжээг авч ажиллав. Тухайлбал,

<sup>1</sup> Албан ёсны статистикийн мэдээллийг эрхлэн гаргахад шаардлагатай статистикийн үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан цогц үйл ажиллагааг тодорхойлж, тайлбарласан загвар юм.

- Тооллого, судалгааны мэдээллийг утсаар цуглуулах дуудлагын төвийг 100 операторын хүчин чадалтай болгож өргөтгөсөн.
- ААНБ-ын 2021 оны тооллогын мэдээллийг цахимаар цуглуулав.
- Судалгаануудын мэдээллийг таблет (CAPI, CATI) болон утсаар цуглуулж ажилласан.
- Тооллого, судалгааны мэдээлэл цуглуулж, боловсруулах 8 программыг 2021 онд шинээр боловсруулж, тооллого, судалгаа, статистикийн мэдээг аймаг, сум, багаас цахимаар, төрийн байгууллагуудаас цахим шуудангаар, мэдээллийн сангаас сервис хэлбэрээр авсан (Хавсралт 6).
- Статистикийн мэдээллийг боловсруулахад CPro, SPSS, Stata, Tableau, Eviews, excel программыг ашиглаж байна.

**Төрийн нэгдсэн мэдээллийн сан: “Төрийн их өгөгдөл” төсөл.** Монгол Улсын нийгэм, эдийн засгийн бодлого, түүний үр нөлөөг оновчтой тодорхойлох, төсвийн зардлыг хэмнэх, мэдээллийн уялдааг хангах, нэгдсэн стандартыг бий болгох, мэдээлэгчийн ачааллыг бууруулах Төрийн их өгөгдөл төслийн танилцуулга, баримт бичгийг боловсруулж, бэлтгэл ажлыг эхлүүлээ.

Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд төрийн байгууллагуудтай өгөгдлийн санг холбох, өгөгдөл солилцох төлөвлөгөө боловсруулж, “Төрийн их өгөгдлийг эдийн засаг, нийгэм болон мэдээллийн технологийн салбарт ашиглах нь” цуврал 3 удаагийн хэлэлцүүлгийг салбарын 300 гаруй төлөөллийг оролцуулж, зохион байгууллаа. Төрийн байгууллагуудын өгөгдлийн санг нэгтгэн уялдуулж, хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх замаар Төрийн нэгдсэн өгөгдлийн санг байгуулснаар бодлого төлөвлөлт, төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох ач холбогдолтой.

### ЗУРАГ 33. ТӨРИЙН ИХ ӨГӨГДӨЛ – БҮРЭН ЗУРАГЛАЛ



**Хүн ам, өрхийн мэдээллийн санг<sup>1</sup>** хүн ам, өрхийн тоо мэдээллийг үнэн зөв тодорхойлох, тооллого хоорондын хүн амын тоог хянах, нийгмийн үзүүлэлтээр мэдээллийн сан бүрдүүлэх, зорилгоор 1998 онд байгуулан тооллогын үр дүнгээр тогтмол шинэчлэн сайжруулж байна. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнгээр мэдээллийг бүрэн шинэчилж, бодлого төлөвлөлтөд шаардлагатай мэдээллийг бий болгосон. Уг сантай Нийгмийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Боловсролын яамны суралцагчдын мэдээллийн санг холбож, зарим судалгааны тооцооллыг хийсэн.

Цаашид банк, татвар, и-баримт, нийгмийн даатгал, халамжийн зэрэг мэдээллийн сангуудтай холбосноор илүү нарийвчилсан мэдээллийг бий болгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, халамжийн бодлого эзнээ олох, нотолгоонд суурилсан бодлого, шийдвэрийг гаргах боломж бүрдэх зэрэг давуу талтай.

**Статистикийн бизнес регистрийн санг<sup>2</sup>** ААНБ-ын 1998 оны анхны тооллогын үр дүнд үндэслэн байгуулж, тооллого, судалгааны үр дүн, Татварын ерөнхий газрын болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлэл, эдийн засгийн салбаруудын мэдээлэлтэй холбож шинэчилж байна. Аж ахуйн нэгж байгууллагын 2021 оны тооллогын үр дүнгээр мэдээллийг бүрэн шинэчиллээ.

Төрийн нэгдсэн өгөгдлийн санг байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Гааль, татварын статистикийн мэдээллийн технологийн төвтэй хамтран и-баримтын системд бараа, ажил үйлчилгээг Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны болон бүтээгдэхүүний нэгдсэн ангиллын дагуу кодлох системийг хөгжүүлэх, уялдуулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна.

## 2.3. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Санхүүгийн үйл ажиллагаа.** Статистикийн салбарын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулж, төсвийн шууд захирагчийн 23 байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авч нэгтгэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн, 2021 оны эхний хагас жилийн тайлан тэнцлийг гаргаж Сангийн яамны и-тайлан программд оруулсан. Үндэсний аудитын газраас 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар 20 байгууллага зөрчилгүй, Сүхбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн статистикийн хэлтэс итгэмжлэл авсан.

Үндсэн хөрөнгийн тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар дүгнүүлэн, гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлж, “Үлгэр жишээ” өргөмжлөлөөр шагнуулав.

ҮСХ-ны үйл ажиллагааны урсгал зардлын төсөв 2021 онд 7.1 тэрбум төгрөг батлагдсанаас 98.1 хувийн санхүүжилтийг зарцуулсан.

---

<sup>2</sup>Аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ, ажиллагчдын тоо зэрэг үндсэн үзүүлэлтийг агуулсан мэдээллийн сан юм.

## ХҮСНЭГТ 7. САЛБАРЫН БАТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, сая төгрөг

|  | Төсвийн ерөнхийлөн захирагч |          | Үүнээс: ҮСХ |         |
|--|-----------------------------|----------|-------------|---------|
|  | 2020                        | 2021     | 2020        | 2021    |
| Батлагдсан төсөв                       | 14,629.9                    | 10,382.1 | 11,409.9    | 7,124.1 |
| Авсан санхүүжилт                       | 13,790.9                    | 10,281.7 | 10,208.3    | 7,023.6 |
| Гүйцэтгэл                              | 13,621.4                    | 10,224.5 | 10,805.1    | 7,016.2 |
| Үүнээс: Үндсэн үйл ажиллагааны зардалд | 6,969.3                     | 6,404.3  | 4,162.5     | 3,204.9 |
| Судалгааны зардалд                     | 6,652.1                     | 3,820.2  | 6,642.6     | 3,811.3 |

ҮСХ-нд хэрэгжиж буй 15 төсөл, хөтөлбөрийн судалгааны 1.5 тэрбум төгрөгийн төлөвлөгөөг батлуулан, холбогдох зардлыг санхүүжүүлж, 1.1 тэрбум төгрөгийг зарцуулсан (Хавсралт 7). НҮБ-ын Хүүхдийн сангаар хэрэгжсэн төсөлд санхүүгийн шалгалт, аудит хийгдэж амжилттай дүгнэгдсэн.

### 2.4. ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын статистикийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд албан ёсны статистикийн шинэчлэл, хөгжлийг дэмжих, харилцан үр өгөөжтэй, бүтээлч хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, олон улсад Монгол Улсын статистикийн байгууллагын нэр хүнд, оролцоог нэмэгдүүлэх зорилт тавьж ажиллалаа.

#### ЗУРАГ 34. ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БАЙГУУЛЛАГУУД

##### ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА



##### ХОЁР ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА



**Олон талт хамтын ажиллагаа.** НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, олон улсын байгууллагуудтай төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, албан ёсны статистикийн үзүүлэлтүүдийг баяжуулах, хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах, статистикийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Тухайлбал,

- НҮБ-ын Хүнс, хөдөө ахуйн байгууллага болон ХХААХҮЯ, ГХЯ хамтран Ази, Номхон далайн орнуудын Хөдөө аж ахуйн статистикийн комиссын 29-р чуулганыг Улаанбаатар хотод анх удаа зохион байгуулж, 31 улсын 300 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо. Тус чуулганаар хөдөө аж ахуй, байгаль орчин, хүнсний аюулгүй байдлын асуудал зэрэг сэдвээр бодлого, шийдвэрт шаардлагатай тоон мэдээллийг бий болгож байгаа олон улсын туршлага, шинэлэг арга аргачлалыг хэлэлцэж, цар тахлын үед тулгамдаж буй асуудал, түүнийг даван туулж байгаа сайн туршлага, ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн тооцоолол, хөдөө аж ахуй, хөдөөгийн статистикийн шинэчлэлийн талаар мэдээлэл солилцов.
- ҮСХ нь Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтийн Бүс дундын шинжээчдийн бүлэг (IAEG-SDG)-ийн 2021-2023 онд Зүүн Азийг төлөөлөх гишүүнээр сонгогдлоо.
- НҮБ-ын АНДЭЗНК-ын Статистикийн товчооны гишүүн, эдийн засгийн болон нийгмийн статистикийн удирдах зөвлөл, Ердийн хөдөлгөөний статистикийн техникийн ажлын хэсэг, ПАРИС21 байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, Хөгжлийн бэрхшээлийн статистикийн Вашингтон группийн гишүүн, ХАА-н статистикийн “50x2030” санаачилгын удирдах зөвлөлийн гишүүн, ЮНЕСКО-гийн удирдах зөвлөлийн гишүүнээр ҮСХ-ны төлөөлөл сонгогдон ажиллаж байна.
- Дэлхийн дата форумд оролцож, “Статистикийн боловсролыг сайжруулах нь” сэдвээр илтгэл тавьж, олон талт болон хоёр талт хамтын ажиллагаатай 7 байгууллагатай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар НҮБХХААБ-ын Статистикийн хэлтсээс Монгол Улсын хөдөө аж ахуйн статистикийн чадавхыг нэмэгдүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж, ҮСХ техник туслалцааны төслийн саналаа НҮБХХААБ-д хүргүүлэхээр тохиролцлоо. НҮБ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгээс хөгжүүлсэн статистикийн сургалтын материал, системийг авч ашиглахаар тохиролцов. Мөн ПАРИС21 байгууллагаас Статистикийн тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах болон Төрийн их өгөгдөл төслийг хэрэгжүүлэхэд техник туслалцаа олгохоор болов.
- НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагатай “Жендерийн статистикийг сайжруулах” төслийг 2019-2021 онд амжилттай хэрэгжүүлж, дуусгалаа.
- НҮБ-ын Статистикийн комиссын 52 дугаар чуулганд 20 гаруй салбар хуралдаанд ҮСХ-ны удирдлага, төлөөлөгчид оролцож, 3 салбар хуралдаанд илтгэгч, чиглүүлэгчээр ажиллаж, 11 асуудлын хүрээнд албан ёсны саналаа хүргүүлж, олон улсын туршлагаас судалсан.
- Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, АХБ, ДБ, ОУВС, Европын холбооны төлөөлөгчийн газрын удирдлагатай уулзалтууд зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцож, “Төрийн их өгөгдөл” төслийн бэлтгэл хангахад

техникийн туслалцаа үзүүлэх, чадавх бэхжүүлэх, хууль эрх зүйн орчныг шинэчлэхэд зөвлөх үйлчилгээ авах тохиролцоонд хүрэв.

Монгол Улсын Засгийн газраас Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаг” төслийн хүрээнд салбарын албан хаагчдын чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулж, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийв.

АХБ-ны дэмжлэгтэйгээр Ази, Номхон далайн орнуудад хэрэгжүүлдэг Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн 2021 оны хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

**Хоёр талт хамтын ажиллагаа.** Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон, Турк, Энэтхэг, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Австрали, Вьетнам, Бангладеш, Финланд, Унгар, Казахстан, Беларусь зэрэг 12 орны статистикийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байна. БНСУ-ын Статистикийн газар болон Японы Статистикийн товчоо, Синфоника байгууллага, Беларусь улсын Статистикийн үндэсний хороотой цахим уулзалт зохион байгуулж ковид-19 нөхцөл байдалд зохион байгуулж байгаа тооллого судалгааны мэдээлэл цуглуулалт, гарч байгаа хүндрэлийг даван туулж байгаа туршлага, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах чиглэлээр Швейцарь, Шинэ Зеланд улсуудын статистикийн байгууллагатай цахим уулзалт зохион байгуулж өгөгдлийн засаглал, стандарт, мэдээллийн нэгдсэн сангийн тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангаж байгаа туршлагыг судаллаа.

Олон талт болон 2 талт хамтын ажиллагаа нь албан ёсны статистикийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, байгууллагын хүний нөөцийн болон технологийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэж, олон улсын статистикийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцлоо.

## 2.5. ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

ҮСХ-ны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалт, аудитыг дараах хүрээнд зохион байгуулж байна.

### Дотоод хяналт шалгалт

- УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас баталсан аргачлалын дагуу Монгол Улсын статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, ҮСХ-ны 2020 оны үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийсэн.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ҮСХ хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилт, ҮСХ-нд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүгнэлтийг Сангийн яаманд хүргүүлсэн.
- ҮСХ-ны дотоод хяналт шалгалтын журмыг шинээр боловсруулан баталж, ҮСХ, аймаг, нийслэлийн статистикийн албадад хүргүүлэн мөрдөн ажиллаж байна.
- Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг шинэчлэн баталж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020, 2021 оны жилийн гүйцэтгэлийн тайланд үнэлгээ, 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн

тайланд явцын хяналт-шинжилгээг хийж, тайлан, зөвлөмжийг газар, хэлтсүүдэд хүргүүлсэн.

- Орон нутгийн нэгжид хийсэн 83 удаагийн хяналт шалгалтын ажлын тайланд үндэслэн эрсдэлийн жагсаалт бэлтгэж, эрсдэлийн үнэлгээг хийв.

Тайлант хугацаанд 142 статистикийн улсын байцаагч ажиллаж байгаагаас 21 аймагт 93, дүүрэгт 21, нийслэл (ҮСХ, нийслэл, яам, агентлагт)-д 28 байгаагаас ҮСХ, аймаг, нийслэл, дүүргийн Статистикийн хэлтэс, газарт 94, эрүүл мэндийн салбарт 26, боловсролын салбарт 20, Төрийн өмчийн хороонд 2 байна. Улсын байцаагч нараас “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хуулийн дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн ажиллагааны мэдээг сар бүр авч, Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын судалгаа, өөрчлөлт хөдөлгөөний мэдээг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлэв.

#### Дотоод аудитын үйл ажиллагаа

- Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн харьяа нэгжүүдийн 2020 оны жилийн эцэс, 2021 оны эхний хагас жилийн худалдан авах үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийж, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- ТЕЗ-ийн 2020 оны жилийн эцсийн худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд дотоод аудит хийж, дүгнэлт гарган, захиалагчид зөвлөмж хүргүүлж, ажилласны үр дүнд Сангийн яамнаас жил бүр төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хийдэг хяналт шинжилгээ, үнэлгээгээр 88 буюу “Сайн” үнэлэгдсэн.
- ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны жилийн эцэс, 2021 оны эхний хагас жилийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн.

#### ЗУРАГ 35. ШИЛЭН ДАНСНЫ АУДИТЫН ҮР ДҮН, 2016-2020 он



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, зөвлөмж хүргүүлж, хяналт тавьж ажилласны үр дүнд 2019, 2020 оны шилэн дансны үйл ажиллагаа сайжирсан. Тухайлбал, Шилэн дансны цахим хуудаст байршуулсан мэдээллийн хугацаа хоцролт 2016 онд 37.5 хувь байсан бол 2020 онд 3.5 хувь болж буурсан.

- ТЕЗ-ийн харьяа нэгжүүдийн 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудитыг хийж дүгнэлт гаргаж, зөвлөмж хүргүүлж ажилласны үр дүнд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар бүх нэгжүүд “Зөрчилгүй” дүгнүүлсэн.

## ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2022 ОНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ



**ЗОРИЛГО 1.**  
**АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКТ ТӨРИЙН ИХ ӨГӨГДЛИЙГ АШИГЛАХ БЭЛТГЭЛ  
АЖЛЫГ ХАНГАХ**

### **ЗОРИЛТ 1**

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН  
ОРЧНЫГ  
БОЛОВСРОНГУЙ  
БОЛГОХ

### **ЗОРИЛТ 2**

ӨГӨГДЛИЙН  
УДИРДЛАГЫГ  
БОЛОВСРОНГУЙ  
БОЛГОХ

### **ЗОРИЛТ 3**

АЛБАН ЁСНЫ  
СТАТИСТИКИЙН  
ШИНЭЧЛЭЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ

### **ЗОРИЛТ 4**

ХҮНИЙ НӨӨЦИЙН  
ЧАДАВХЫГ  
БЭХЖҮҮЛЭХ

### **ЗОРИЛТ 5**

АЛБАН ЁСНЫ  
СТАТИСТИКИЙН  
МЭДЭЭЛЛИЙГ  
ЭРХЛЭН ГАРГАХ

### **ЗОРИЛТ 6**

СТАТИСТИКИЙН  
ҮЗҮҮЛЭЛТ,  
АРГАЧЛАЛЫГ  
ОЛОНУЛСЫН  
ЖИШИГТ  
НИЙЦҮҮЛЭН  
ГАРГАЖ, МӨРДӨХ



**ЗОРИЛГО 2.**  
**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЛЭЭ, АШИГЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ**

### **ЗОРИЛТ 1**

СТАТИСТИКИЙН  
МЭДЭЭЛЛИЙН  
ТАРХААЛТЫГ  
ШИНЭЛЭГ  
ХЭЛБЭРЭЭР  
ӨРГӨТГӨХ



## ГУРАВ. ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ

### ОРШИЛ

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо (цаашид ҮСХ гэх)-ны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үйл ажиллагааны тайланд Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газраас хийсэн системчилсэн үнэлгээг танилцуулж байна.

ҮСХ-ны 2021 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээнд чиг үүргийн хэрэгжилт, анхан шатны нэгжийн хүний нөөцийн хэрэгцээг хамруулав.

### ХҮСНЭГТ 8. ҮСХ-НЫ 2016-2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СЭДЭВ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА

| Он   | Үнэлгээний  |  | Арга сонгосон шалтгаан   |
|------|---|--|--|
|      | Сэдэв   | Арга   |  |
| 2017 | ҮСХ-ны 2016 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээ                 | <ul style="list-style-type: none"> <li>• Баримт бичиг судлах</li> <li>• Ажиглалт хийх</li> </ul>   | Албан ёсны статистикийн үйл ажиллагаа нь салбарын хэмжээнд тасралтгүй үргэлжилдэг учраас үнэлгээний тайланд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын албан ёсны статистиктай холбоотой үйл ажиллагаа орсон. |
| 2018 | ҮСХ-ны чиг үүрэг, хүний нөөцийн хэрэгцээ                                    | <ul style="list-style-type: none"> <li>• Баримт бичиг судлах</li> <li>• Ажиглалт хийх</li> <li>• Санал асуулга авах</li> </ul>           | Ажлын байрны зорилго, ажилтны чиг үүргийн уялдаа, ажлын ачаалал болон ажлын байран дахь сэтгэл ханамжийн талаар тайланд тусгасан учир 3 аргыг хослуулан хэрэглэсэн.  |
| 2019 | Анхан шатны нэгжид мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа, хүний нөөцийн хэрэгцээ | <ul style="list-style-type: none"> <li>• Баримт бичиг судлах</li> <li>• Ярилцлага хийх</li> <li>• Санал асуулга авах</li> </ul>          | Анхан шатны нэгжээс мэдээлэл цуглуулах, нэгтгэх, хянаж шалгах үйл ажиллагаа, хүний нөөц, орон тоо, бүтцийн талаар үнэлгээ хийсэн.  |
| 2020 | ҮСХ-ны 2019 оны үйл ажиллагаа   | <ul style="list-style-type: none"> <li>• Баримт материалыг судлах</li> <li>• Дүн шинжилгээ хийх</li> <li>• Санал асуулга авах</li> </ul> | ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, үйл ажиллагааны журам (процессын), хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ, төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.  |
| 2021 | ҮСХ-ны 2020 оны үйл ажиллагаа   | <ul style="list-style-type: none"> <li>• Баримт материалыг судлах</li> <li>• Дүн шинжилгээ хийх</li> <li>• Санал асуулга авах</li> </ul> | ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, хүний нөөцийн хэрэгцээний үнэлгээ, төсөв санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан.   |

| Он   | Үнэлгээний   |  | Арга сонгосон шалтгаан  |
|------|--|--|---|
|      | Сэдэв  | Арга   |   |
| 2022 | ҮСХ-ны чиг үүрэг, анхан шатны нэгжийн хүний нөөцийн хэрэгцээ | <ul style="list-style-type: none"> <li>• Баримт материалыг судлах</li> <li>• Дүн шинжилгээ хийх</li> <li>• Санал асуулга авах</li> </ul> | ҮСХ-ны чиг үүргийн хэрэгжилт, анхан шатны нэгжийн хүний нөөцийн хэрэгцээг хамруулсан. |

Системчилсэн үнэлгээг Хууль зүйн яам (тухайн үеийн нэрээр)-наас боловсруулсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн.

Түүнчлэн ҮСХ-ны 2021 оны үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад баримт материалыг судалж, дүн шинжилгээ хийсэн бөгөөд зарим асуудлыг тодруулахад санал асуулга авсан.

## ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ БОЛОН ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

### Байгууллагын чиг үүргийн хэрэгжилт

ҮСХ нь Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-ыг нэвтрүүлэх хүрээнд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах 15 зорилтын хүрээнд 90 ажлыг төлөвлөн ажиллажээ. Үүнд:

1. Удирдлага зохицуулалтыг хангах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, тархаах;
3. Тооллого, судалгааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, үр дүнг боловсруулах, тархаах;
4. Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж, мөрдүүлэх;
5. Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтээр тооцоо, загварчлал, шинжилгээ, судалгааны ажил хийх;
6. Тогтвортой хөгжлийн зорилт (цаашид ТХЗ гэх)-ын шалгуур үзүүлэлтүүдийг бий болгох;
7. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах;
8. Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх;
9. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;
10. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
11. Төсөв батлуулах, хуваарилах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
12. Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, дотоод аудит хийх;
13. Албан ёсны статистикийн мэдээллийн чанар, бодит байдал, уялдаа холбоо, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах;

14. Мэдээлэл тархаалтын олон улсын стандартад нийцсэн тогтолцоог бүрдүүлэх;

15. Хэрэглэгчийн статистикийн боловсролыг дээшлүүлэх.

ҮСХ-ны газар, нэгжийн болон төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх ажлуудыг уялдуулан тусгажээ.

Үндэсний статистикийн салбарын хөгжлийн бодлогыг төрийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан сайжруулсан байна. Тухайлбал:

- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний төлөвлөлтийн уялдаа, холбоог ханган ажиллажээ.
- ҮСХ нь “Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд тайлагнаж, статистикийн салбарын дунд хугацааны зорилго, зорилтыг тодорхойлж, 2021-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж байна.

“Статистикийн салбарын 2021-2025 оны стратеги төлөвлөгөөг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд боловсруулж, ҮСХ-ны даргын 2021 оны А/114 дүгээр тушаалаар баталсан. Стратеги төлөвлөгөөнд үндсэн 9 чиг үүргийн хүрээнд 4 зорилт дэвшүүлж, 23 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 51.6 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Стратеги төлөвлөгөөтэй уялдуулан ҮСХ-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тодотгол хийж, 6 ажлыг нэмж хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

ҮСХ-ны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Тамгын газар 96.0 хувьтай тайлагнасан байна. Биелэлтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлэхэд 88 ажил бүрэн хэрэгжсэн<sup>3</sup>, 5 ажил хэрэгжих шатандаа<sup>4</sup>, 3 ажил хэрэгжилт хангалтгүй<sup>5</sup> байна.

<sup>3</sup> “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

<sup>4</sup> “хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

<sup>5</sup> “хэрэгжилт хангалтгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);

## ХҮСНЭГТ 9. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

| №           | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэсэг   | Зорилт    | Арга хэмжээ | Хэрэгжилтийн үнэлгээ |                 |                      |             |
|-------------|--|-----------|-------------|----------------------|-----------------|----------------------|-------------|
|             |  |           |             | Бүрэн хэрэгжсэн      | Хэрэгжих шатанд | Хэрэгжилт хангалтгүй | Хэрэгжээгүй |
| 1           | Нэгдүгээр хэсэг.<br>Бодлогын баримт бичиг болон хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт | 12        | 71          | 66                   | 2               | 3                    | 0           |
| 2           | Хоёрдугаар хэсэг.<br>Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт                  | 3         | 25          | 22                   | 3               | 0                    | 0           |
| <b>Нийт</b> |  | <b>15</b> | <b>96</b>   | <b>88</b>            | <b>5</b>        | <b>3</b>             | <b>0</b>    |

Хэрэгжилт дутуу 8 ажлын шалтгааныг тодруулбал:

Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувьтай ажлууд:

1. Салбарын бодлогын зохицуулалтыг хангах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд боловсруулсан Статистикийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өөрчилж, УИХ-д нэмэлт хуулийн өөрчлөлтөөр өргөн барих саналаар хойшлуулж, 2022 оны төлөвлөгөөнд шилжүүлсэн.
2. Эдийн засаг, нийгмийн үзүүлэлтээр тооцоо, загварчлал, шинжилгээ, судалгааны ажил хийх зорилтын хүрээнд өрхөд суурилсан түүвэр судалгаа, Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем (цаашид НӨАТУС гэх)-ийн мэдээллийн сан зэрэг өгөгдлийг ашиглахаар төлөвлөжээ. Туршилтын явцад НӨАТУС-ийн мэдээллийн сан ашиглан хэрэглээний үнийн индексийг жинлэхэд статистик алдаа их гарсан, түүнчлэн шинээр ашигласан зарим мэдээллийн эх үүсвэрт хувиараа хөдөлмөр эрхлэгчийн үйл ажиллагаа багтаагүй, худалдан авалтыг өрх, аж ахуйн, нэгж байгууллага (цаашид ААНБ гэх), Засгийн газрын хэрэглээгээр ангилж боломжгүй байв. Иймд 2021 оны сүүлийн хагас жилийн Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнтэй хамтад нь нэмж тооцоолол хийхээр хойшлуулсан.
3. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах зорилтын хүрээнд хүний нөөцийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж, бодлогын баримт бичгийг боловсруулж байна.

Хэрэгжих шатандаа буюу 70 хувьтай ажлууд:

1. Албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, тархаах зорилтын хүрээнд хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн салбарын 2020 оны 32 танилцуулгыг бэлтгэн тархаахаас 7 танилцуулгыг тархаагаагүй байна. Үүнд: Гэр бүл, Худалдаа, үйлчилгээ, Хөгжлийн бэрхшээл, Нийгмийн даатгал, халамж, Статистикийн бизнес регистр, Байгаль орчин, Барилгын танилцуулга.
2. Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх зорилтын хүрээнд мэдээлэл боловсруулах үйл ажиллагааг

автоматжуулах, хялбарчлах зорилгоор Статистикийн мэдээлэл боловсруулах систем (SPS)-ийг нэвтрүүлж байна. Албан ёсны болон захиргааны мэдээ тайланг статистикийн мэдээлэл боловсруулах системд шилжүүлэх төлөвлөгөөнд 52 мэдээ, тайланг шилжүүлэхээс 10 мэдээ, тайланг шилжүүлсэн, 33 мэдээ, тайланг бэлтгэж шилжүүлэхэд бэлэн болгосон, 9 мэдээ, тайланг боловсруулаагүй байна.

3. Албан ёсны статистикийн мэдээллийн чанар, бодит байдал, уялдаа холбоо, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилтын хүрээнд төрийн байгууллагуудад статистикийн ангилал, аргачлал, арга зүйн байдалд мониторинг хийж, албан ёсны статистикийн үйл ажиллагаанд мөрдүүлэх, холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажил коронавируст халдвар (ковид-19) цар тахлаас шалтгаалж хойшилжээ.
4. Мэдээлэл тархаалтын олон улсын стандартад нийцсэн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд статистикийн мэдээллийг аймаг, сум, багийн түвшинд “Статистикийн газарзүйн мэдээллийн сан”-д байршуулах сургалтыг коронавируст халдвар (ковид-19) цар тахлаас шалтгаалан хойшлуулжээ. Аймгийн статистикийн хэлтсийн мэргэжилтэн нь аймаг, сум, багийн хилийн полигон, орон зайн мэдээллийг веб сервисээр дамжуулан бэлтгэж, веб газрын зураг боловсруулах чадварыг эзэмшиж, цаашид хариуцан ажиллана. Иймд ажилтан сургалтад зайлшгүй биечлэн оролцох шаардлагатай тул хойшлуулжээ.
5. Дээрх 14 дүгээр зорилтын хүрээнд мэдээлэл тархаалтын бодлого боловсруулах зорилгоор мэдээлэл тархаалтын бодлого, статистикийн мэдээллийн санг ашиглах журмын төслийг боловсруулсан байна.

Мөн холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо хүрсэн, үр дүн гарсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу “Бүрэн хэрэгжсэн<sup>6</sup>” гэж үнэлсэн боловч зарим шалтгааны улмаас 90 хувьтай үнэлэгдсэн ажлуудыг тодруулбал:

1. Тооллого, судалгааны бэлтгэлийг хангах, зохион байгуулах, үр дүнг боловсруулах, тархах зорилтын хүрээнд хийх хөдөө аж ахуйн 2022 оны тооллогын үзэл баримтлалыг эцэслэн батлуулаагүй.
2. Дээрх 5 дугаар зорилтын хүрээнд Байгаль орчин, эдийн засгийн дансны системийн хүрээний дансуудыг 2020 оны гүйцэтгэлээр байгуулж, танилцуулга бэлтгэх ажлаас эрчим хүчний биет урсгалын данс, байгаль орчныг хамгаалах зардлын дансыг байгуулж, танилцуулга бэлтгэсэн боловч тархаагаагүй.

ҮСХ-ны дарга 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүн, 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлаа жилийн тайлангийн хуралд танилцуулсан байна. Тайлангийн хуралд удирдлагын зүгээс тухайн газар, нэгжийн 2021 оны үйл ажиллагааг дүгнэж, 2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд нийт ажилтнаас санал авч, хэлэлцжээ.

ҮСХ-ны даргын 2021 оны А/207 дугаар тушаалаар төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх үнэлгээний баг байгуулж, төрийн жинхэнэ албан хаагчийн 2021 оны гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн байна.

ҮСХ-ны даргын 2018 оны А/148 дугаар тушаалаар баталсан журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсийн 2021 оны ажлын

<sup>6</sup> “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

үр дүнг албан ёсны статистикийн мэдээлэл, тооллого, судалгаа, статистикийн мэдээлэл, тархаалт, сурталчилгаа, төрийн захиргаа, сургалтын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаа гэсэн 5 бүлгийн хүрээнд 15 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэжээ.

ҮСХ-ны даргын 2020 оны А/76 дугаар тушаалаар албан ёсны болон захиргааны статистикийн 2021 оны мэдээ тайлангийн графикийг баталж, яам, төрийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтэст хүргүүлжээ. ҮСХ нь 2021 оны графикийн дагуу албан ёсны статистикийн 53 төрлийн мэдээг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газраас 51 маягтаар, яам, агентлаг, төрийн бусад байгууллагаас 7 хоног, 14 хоног, сар, улирал, жилийн давтамжаар 365 маягтаар цуглуулан авч, боловсруулан, үр дүнг хэрэглэгчдэд тархаасан байна. Улсын хэмжээнд 2021 онд 2 тооллого, 17 түүвэр судалгааг цаг хугацаанд нь зохион байгуулжээ.

ҮСХ нь Статистикийн тухай хуульд заасны дагуу жил бүр зохион байгуулдаг Мал, тэжээвэр амьтдын тооллого, 3 жил тутамд зохион байгуулдаг хашаа худгийн тооллого, 5 жил тутам зохион байгуулдаг аж ахуйн нэгж байгууллагын тооллогыг амжилттай зохион байгуулжээ.

#### Мал, тэжээвэр амьтдын тооллого:

Мал, тэжээвэр амьтдын 2021 оны жилийн эцсийн тооллоготой хамт 3 жил тутамд зохион байгуулдаг хашаа худгийн тооллогыг хийж, үр дүнг урьдчилсан байдлаар тархаасан байна.

Системчилсэн үнэлгээний хүрээнд анхан шатны нэгжээс ирүүлж буй тооллого судалгааны болон бусад мэдээллийг улам сайжруулах зорилгоор мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулахад тулгардаг хүндрэл бэрхшээлийг судалсан.

Судалгаанд аймгийн статистикийн хэлтсийн 129 ажилтны 96.1 хувь, 330 сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний 84.5 хувь, 1639 багийн Засаг даргын 65.8 хувь нь оролцов.

Мал, тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулах зардлын эх үүсвэрийг Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолоор Үндэсний Статистикийн газар болон бүх шатны Засаг даргын Тамгын газар (Цаашид ЗДТГ гэх)-ын жил бүрийн төсөвт тооцон тусгаж, санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгожээ.

Гэвч бүх шатны ЗДТГ-аас мал, тэжээвэр амьтдын тооллогыг өрхөд биечлэн очиж, нүдээр тоолох шалгуурыг хангах зардлыг жил бүрийн төсөвт тооцон тусгаж, санхүүжүүлдэггүй байна. Энэ нь мал, тэжээвэр амьтдын тооллогын чанарт сөргөөр нөлөөлдөг.

Судалгаанд оролцсон багийн Засаг дарга нарын 52.3 хувь нь “мал тооллогын шатахууны хуваарилсан зардал нь өрхөд очиж, нүд үзэж малыг тоолоход хүрдэггүй” гэжээ. Судалгааны дүнгээр 2021 оны мал, тэжээвэр амьтдын тооллогын шатахууны зардал нэг сумын түвшинд 250.0-3,800.0 мянган төгрөг байна.

Судалгаанд оролцсон сумын статистикийн мэдээ хариуцсан төсөв, төрийн сангийн мэргэжилтний 61.1 хувь нь холбооны зардал байхгүй, 38.9 хувь нь тодорхой хэмжээний зардал батлуулдаг гэжээ. Нэг суманд дунджаар 150.0 мянган төгрөгийн, нэг багт дунджаар 30.0 мянган төгрөгийн холбооны зардал ногдож байна.

Судалгаанд оролцсон аймгийн статистикийн хэлтсүүд дараах хүндрэлийг ихэвчлэн жишээ болгон дурдсан. Тухайлбал: Аймгийн түвшинд жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын зардал тодорхой биш. Учир нь Сангийн яамнаас “аймаг, нийслэлд тооллого, судалгаанд зориулсан зардлын эдийн засгийн ангилал байхгүй” гэх шалтгаанаар Засаг даргын нөөц хөрөнгө гэх зэрэг өөр ангилалд тусгадаг. Тэр зардлыг зарцуулах болохоор Засаг даргын нөөц хөрөнгө дууссан гэх мэтээр шалтаглан санхүүжилт дутуу эсвэл огт хийдэггүй. Зөвхөн Увс, Сүхбаатар, Өмнөговь, Завхан аймаг болон нийслэл хот зэрэг зарим засаг захиргааны нэгжүүд л мал, тэжээвэр амьтдын тооллогын зардлыг төсөвт төлөвлөж, зарцуулжээ.

#### Аж ахуйн нэгжийн тооллого:

Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “з”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 315 дугаар тогтоолын дагуу улс орон даяар зохион байгуулжээ.

Коронавируст халдвар (ковид-19) цар тахлын хөл хориотой үед тооллогын тов таарсан тул хугацаа, төлөвлөлт, зохион байгуулалтад сөргөөр нөлөөлсөн байна. Программын туршилтыг хангалттай хугацаанд хийж чадаагүй тул тооллогын эхний хэдэн хоногт программын засвар, сайжруулалт хийж, тооллогын хугацааг 2 хоногоор сунгах шаардлага тулгарсан.

Энэ удаагийн тооллогыг шинэ аргачлал, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан амжилттай хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Тооллогын асуулгад нэмэлт мэдээлэл оруулсан:
  - ✓ ААНБ-ын үйлдвэрлэл, үйлчилгээний газрын эзэмшлийн хэлбэр;
  - ✓ и-баримтын системд холбогдсон байдал;
  - ✓ ТХЗ-ыг дэмжсэн үйл ажиллагаа явуулсан байдал;
  - ✓ ISO стандартыг нэвтрүүлсэн байдал;
  - ✓ Хүний нөөцийн дутагдал, шаардлагатай мэргэжлийн чиглэл, шаардлагатай ажилтнаа олж чадахгүй байгаа шалтгаан;
  - ✓ Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад төрийн байгууллагаас шаарддаг баримт бичиг, тодорхойлолт;
  - ✓ Үйл ажиллагаандаа ашигладаг сүлжээний төрөл;
  - ✓ Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо;
  - ✓ Олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн байдал, экспортод бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргасан байдал;
  - ✓ Үйлдвэрлэлийн зориулалттай машин, тоног төхөөрөмж;
  - ✓ Коронавируст халдвар (ковид-19) тахлын нөлөөлөл, үйл ажиллагааны орлого,
  - ✓ Бизнесийн төлөв байдал, хандлага;
  - ✓ Инновац, судалгаа хөгжүүлэлтийн ажил;
  - ✓ Анх удаа хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эдийн засгийн үзүүлэлт, үндсэн болон хоёрдогч үйл ажиллагаа, ажиллагчдын тоо, борлуулалтын орлогын хэмжээ, байрны эзэмшлийн хэлбэр, коронавируст халдвар (ковид-19) тахлын нөлөө, бизнесийн төлөв байдал, зээлтэй эсэх, и-баримтын системд холбогдсон талаарх мэдээллийг цуглуулж, мэдээллийн сан бүрдүүлсэн.

- Тооллогоор хаягийн орон зайн мэдээллийн санд суурилан ААНБ-ын байршлыг тодорхойлж, газар зүйн мэдээллийн санг шинэчилсэн.
- Тооллогын мэдээлэл цуглуулах ажлыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан. Ингэснээр маягт хэвлэлийн зардлыг эрс бууруулсан. Цаашид цахимаар тооллого, судалгааг явуулахад хөдөө орон нутгийн алслагдсан, интернэтийн сүлжээ муу сумын түвшинд программд нэвтрэх, мэдээллээ шивэх, технологийн болон бусад шийдлийг олоход Засгийн газар, түүний холбогдох агентлагийн дэмжлэгийг авч хамтран ажиллах шаардлагатай байна.

ҮСХ нь албан ёсны статистикийн мэдээллийн найдвартай шинэ эх үүсвэрийг бий болгох чиглэлээр 2021 онд санаачилгатай ажилласныг онцлох нь зүйтэй юм. Мэдээлэгчийн ачааллыг бууруулах, мэдээллийн давхардлыг арилгаж, төсвийн зардлыг хэмнэх, статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн их өгөгдлийг бодлогын шийдвэрт ашиглах нь” төслийн баримт бичиг, танилцуулгыг санаачлан боловсруулсан байна. Энэ төслийг хэрэгжүүлбэл төрийн байгууллагуудад байгаа салангид задгай өгөгдлийн уялдаа эрс сайжирч, мэдээллийн хүрээ, ашиглалт нэмэгдэх, нууцлал, аюулгүй байдлыг хангах замаар хөгжлийн аливаа бодлого боловсруулах, төрийн үйлчилгээг сайжруулах өгөгдлийн санг бий болгох нөхцөл бүрдэх юм.

Олон улсын стандартад нийцүүлэн статистикийн аргачлал, ангилал, түүврийн арга зүйг сайжруулан боловсруулснаар албан ёсны статистикийн тооллого, судалгаа, мэдээний хүрээ тэлж, хэрэглэгчдэд тархаах үзүүлэлтийн тоо, хүртээмжийг нэмэгдүүлжээ. Тухайлбал: Дэлхийн ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тооцох, өргөжүүлэх зорилгоор 2021 онд ҮСХ-ноос баталсан 5 аргачлал, тооллогын 1 асуулгад манай улсад тооцохгүй байгаа болон сайжруулах шаардлагатай 17 үзүүлэлтийг тусгаж, тооцох аргачлалыг боловсруулжээ.

ҮСХ нь 2021 онд мэдээлэл тархаалтын чиглэлээр дараах шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))-ийн бүтцийг хэрэглэгчдэд улам бүр ойлгомжтой байдлаар шинэчилжээ. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан ([www.1212.mn](http://www.1212.mn))-ийн цахим хуудасны хандалт өмнөх оноос 19.2 хувь, ҮСХ-ны албан ёсны цахим хуудас ([www.nso.mn](http://www.nso.mn))-ын хандалт 49.9 хувь, фейсбүүк ([www.facebook.com/StatisticMGL](https://www.facebook.com/StatisticMGL)) хуудасны хандалт 15.3 хувиар тус тус өссөн байна.

### **Анхан шатны нэгжийн хүний нөөц**

ҮСХ нь 2021 оны эхний 7 сард Тамгын газар, Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газар, Хүн ам, нийгмийн статистикийн газар, Эдийн засгийн статистикийн газар, Мэдээллийн технологийн газар, Дотоод аудит, мониторингийн хэлтэс гэсэн газар, нэгжтэй ажиллаж байсан.

Статистикийн үйл ажиллагааны ерөнхий загвар (GSBPM)-ыг нэвтрүүлэх ажлын хүрээнд ҮСХ-ны зохион байгуулалтын бүтэц, газар, нэгжийн чиг үүргийг ҮСХ-ны даргын 2021 оны А/115 дугаар тушаалаар шинэчлэн баталжээ. Энэ тушаалын дагуу 2021 оны 8 дугаар сараас Бодлого, хамтын ажиллагааны газар, Дотоод аудит, эрсдэлийн удирдлагын газар, Мэдээллийн технологийн газар, Нийгмийн статистикийн газар, Нэгдсэн статистикийн газар, Тамгын газар, Тооллого, өгөгдлийн шинжилгээний газар, Эдийн засгийн статистикийн газар гэсэн нийт 8 нэгжид 123 ажилтан, 21 аймаг, нийслэл хот, түүний 8 дүүргийн статистикийн газар, хэлтэст 197 ажилтан, нийт 320 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулсан байна.




Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Монгол Улсын статистикийн байгууллагын тогтолцоо нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан байдлаар улс, орон нутгийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлдэг ҮСХ, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтсээс бүрдэнэ.

Суманд статистикийн үйл ажиллагааг сумын ЗДТГ-ын уг ажлыг хариуцсан ажилтан, баг, хороонд тэдгээрийн Засаг дарга эрхлэн гүйцэтгэнэ” гэж заасан. Энэ хуулийн дагуу нийслэл хот, түүний 9 дүүрэг, 21 аймгийн статистикийн газар, хэлтэст 197 албан хаагч, 330 суманд төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, 1639 баг, 169 хороонд тухайн шатны Засаг дарга албан ёсны статистикийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Статистикийн тухай болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баг, хорооны Засаг дарга нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид албан ёсны статистикийн үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хүн ам, өрхийн мэдээллийг статистикийн “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-д оруулж, тухай бүр баяжилт хийх,
- Албан ёсны статистикийн 12 мэдээг сар, улирал, хагас жил, жилийн давтамжаар өрх, ААНБ-аас цуглуулан авч сумын Засаг даргад мэдээлэх,
- ҮСХ-ноос зохион байгуулах тооллого, түүвэр судалгааны ажлыг зохион байгуулах

ЗУРАГ 36. БАГИЙН ЗАСАГ ДАРГЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, дүнд эзлэх хувиар



Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д Засаг даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байхаар заасны дагуу 2021 онд багийн Засаг дарга нарын сонгуулийн үр дүнгээр 884 (53.9 хувь) нь солигдож, бусад шалтгаанаар 85 (5.2 хувь) нь өөрчлөгджээ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4.1-т багийн Засаг дарга нарыг дээд боловсролтой байхаар тусгаж, уг заалтыг 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиас эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна.

Ажлын туршлагын хувьд нийт багийн Засаг дарга нарын 38.8 хувь нь 4 жил хүртэл, 31.5 хувь нь 5-10 жил, 13.3 хувь нь 11-15 жил, 16.4 хувь нь 16-аас дээш жил ажиллажээ. Харин багийн Засаг даргаар 42.9 хувь нь 1 хүртэл жил, 8.2 хувь нь 2 хүртэл жил, 8.3 хувь нь 2-4 жил, 40.6 хувь нь 5-аас дээш жил ажилласан байна.

**ЗУРАГ 37. БАГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН МЭРГЭЖИЛ, дүнд эзлэх хувиар**



ҮСХ-оос статистикийн анхан шатны мэдээ, тайлан, тооллого судалгааг багийн түвшинд хариуцдаг багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтыг орон нутгийн сонгуулийн дараагаар зохион байгуулдаг.

Багийн Засаг дарга нарын 59.1 хувь нь 2021 онд шинээр томилогдсон байна. Шинээр томилогдсон багийн Засаг даргыг сургаж чадавхжуулахад тэдний боловсрол, мэргэжлээс хамаарч 2 болон түүнээс дээш сургалт хийх шаардлагатай.

ҮСХ, аймгийн статистикийн хэлтсээс зохион байгуулсан статистикийн сургалтад судалгаанд оролцогчдын 17.2 хувь нь хамрагдаагүй, 46.6 хувь нь 1 удаа, 17.5 хувь нь 2 удаа, 6.8 хувь нь 3 удаа, 12.0 хувь нь 4-өөс дээш удаа оролцсон байна.

Судалгаанд оролцсон багийн Засаг дарга нарын 29.3 хувь нь компьютер, 25.5 хувь нь статистикийн сургалт, 25.3 хувь нь интернэт, дата багц, 17.7 хувь нь принтер, 2.2 хувь нь бусад зүйл шаардлагатай байгааг дурдсан.

Мөн багийн Засаг дарга нарын 21.4 хувь нь албан хэрэгцээнд ашиглах компьютергүй байна. Харин албан хэрэгцээндээ компьютертой 846 багийн даргын 57.0 хувь нь ажлын шаардлага хангахгүй компьютертой гэжээ. Албан хэрэгцээнд ашиглаж байгаа компьютерын 79.1 хувь нь 2014 оноос өмнө үйлдвэрлэсэн байна.

“Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-д хүн амын өөрчлөлт, хөдөлгөөний шинэчлэлтийг хийхдээ багийн Засаг дарга нарын 17.6 хувь нь сумын ЗДТГ-ын ажилтнуудын ашиглаагүй байгаа сул компьютер, 12.9 хувь нь хувийн компьютер ашиглаж байгаа нь мэдээллийн нууцлал алдагдах эрсдэлтэй байна.

Нийслэлийн Статистикийн газар (цаашид НСГ гэх), дүүргийн статистикийн хэлтсээс нэгдсэн удирдлагаар хорооны статистик, мэдээ, тайлан хариуцсан албан хаагчид заавар зөвлөгөө өгч, хамтран ажилладаг. Нийслэл хотын 169 хорооны статистикийн мэдээ, тайлан хариуцсан албан хаагчийн 16.3 хувь нь магистр, 83.7 хувь бакалавр болон дипломын дээд боловсролтой байна. Тэдний 70.5 хувь нь 5-аас дээш жилийн ажлын туршлагатай, ялангуяа хороонд ажилласан жилийг авч үзвэл: 33.1 хувь нь 1 жил хүртэл, 33.7 хувь нь 2-4 жил, 22.9 хувь нь 5-8 жил, 10.2 хувь нь 9-ээс дээш жил ажиллаж байна.

Статистикийн тухай хуульд заасан чиг үүргийн хүрээнд хорооны Засаг дарга/ажилтан нь 17 төрлийн мэдээг сар, улирал, жилийн давтамжтай цуглуулж, дүүргийн статистикийн хэлтэст дамжуулдаг. “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-г тухай бүр баяжуулан ажиллаж байна.

**Сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний** албан тушаалын тодорхойлолтын албан тушаалын зорилгод “нутаг дэвсгэрийн хэмжээнд төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн байгууллагуудад төрийн сангийн үйлчилгээ үзүүлэх, статистикийн мэдээллийг хариуцан ажиллаж, ажлын гүйцэтгэлийн үр дүнг сумын ЗДТГ-ын даргын өмнө хариуцна” гэж заасан

байна. Дээрх зорилгыг хэрэгжүүлэх албан тушаалын 4 дүгээр зорилтод “сумын статистик мэдээллийн нэгтгэлийг холбогдох тасаг, нэгж, албан тушаалтнаас ирүүлсэн мэдээнд үндэслэн Сангийн сайд, ҮСХ-ны даргын хамтарсан тушаалын дагуу боловсруулж холбогдох байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх”-ээр заажээ.

Албан тушаалын тодорхойлолтын дагуу “Сумын статистик мэдээ, тайлан тооллого судалгаа, мэдээллийн санг хөтөлж, холбогдох нэгж, байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах” үүргийг сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүд гүйцэтгэж байна.

Сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь багийн Засаг даргаас сар, улирал, жилийн давтамжтай цуглуулсан 12 төрлийн мэдээ, 1 түүвэр судалгаа, 1 тооллогын мэдээллийг хянаж, сумын түвшинд нэгтгэдэг. Үүнээс гадна ҮСХ-ны даргын баталсан мэдээний графикийн дагуу албан ёсны статистикийн 4 мэдээг сар бүр, 10 мэдээг улирал бүр, 2 мэдээг жилээр цуглуулан авч, аймгийн статистикийн хэлтэст дамжуулж байна.

ҮСХ-ны дарга, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 1/48, 88 дугаар тушаалаар албан ёсны статистикийн үйл ажиллагааг хавсран гүйцэтгэж буй сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэнд цалингийн 20 хувийн нэмэгдлийг 2012 оны 4 дүгээр сараас 2019 оны 7 дугаар сар хүртэл олгож байсан.

Төрийн албаны тухай хуулийн дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод сумын статистикийн мэдээллийг хариуцахаар зааснаас хойш нэмэгдэл цалин, урамшуулал олгохыг зогсоон.

Системчилсэн үнэлгээний хүрээнд хийсэн судалгаанд сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний 84.5 хувь нь оролцсон.

Төсөв, төрийн сангийн нийт мэргэжилтний 31.9 хувь нь 1 жил, 12.5 хувь 2 жил, 17.6 хувь нь 3-5 жил, 38.0 хувь нь 6-аас дээш жил тухайн албан тушаалд ажиллаж байна.

Сумын төрийн сангийн ажилтны санхүүгийн тайлангийн хугацаа статистикийн мэдээ, тайлангийн хугацаатай давхцаж тухайн хугацаанд ажлын ачаалал нь нэмэгддэг.

Энэ ачааллыг албан ёсны статистикийн болон төрийн сангийн мэдээллийн урсгал, тайлагнах хугацааны аль нэгэнд өөрчлөлт оруулж багасгах боломжтой.

Судалгаанд оролцогчдын 87.8 хувь нь төрийн сангийн мэдээ, тайлан гаргах, статистикийн мэдээ, тайлан, тооллого судалгаа зохион байгуулах, хянах, дамжуулах хугацаа сар, улирал, хагас жил, жилийн хувьд давхцадаг гэжээ.

**ЗУРАГ 38. СУМЫН ТӨРИЙН САНГИЙН АЖИЛТНЫ АЖЛЫН АЧААЛАЛ, дүнд эзлэх хувиар**



Судалгаанд оролцсон сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүд дараах ажлын хүндрэлийг дурдсан:

- Албаны компьютерт статистикийн программ, төрийн сангийн программ зэрэг ажиллах боломжгүй. Шалтгаан нь төрийн сангийн программ тусгай дотоод сүлжээгээр, статистикийн программ интернэтээр ажилладаг тул заавал сүлжээний ланг сольж программаа ажиллуулдаг;
- Компьютерын хүчин чадал муу, гацдаг;
- Мэдээ, тайлангийн давтамж их;
- Мэдээ, судалгаа бүр дээр багийн Засаг даргад дахин давтан зааварчилгаа өгөх шаардлага гардаг тул тээвэр, холбооны зардал хүрдэггүй;
- Багийн Засаг дарга статистикийн мэдээг хугацаанд нь өгдөггүй, цаг хугацааг нь тулгаж өгдөг, ирүүлсэн мэдээ тайлан балансын алдаатай;
- Багийн Засаг дарга нарт тэр бүр албаны компьютер байхгүй, компьютер болон программ дээр ажиллах чадвар муу;
- Багийн Засаг дарга нь улс төрийн албан тушаалтан тул шаардлага биелүүлдэггүй;
- Шинэ томилогдсон багийн Засаг дарга нарыг зайлшгүй чадавхжуулах шаардлагатай байгааг дурдсан байна.

Монгол Улсын үндэсний статистикийн системд 2013 онд хийсэн олон улсын цогц үнэлгээний зөвлөмжид сумын түвшинд гүйцэтгэх үүрэг хариуцлагын хэмжээ, түвшин өнөөдрийн хэмжээ, түвшиндээ хэвээр үлдэнэ гэвэл ҮСХ нь сум бүрд статистикийн үндсэн ажилтантай байх боломжийг эрэлхийлэх хэрэгтэй гэжээ.

ҮСХ-ны 2020 оны үйл ажиллагаанд хийсэн системчилсэн үнэлгээний тайланд “ҮСХ-оос суманд статистикийн чиг үүргийг хариуцсан орон тоотой болох хэрэгцээ, шаардлага байгааг 2017, 2018 онуудад холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж байсан” талаар тусгасан байна.

Нэгдсэн үндэсний байгууллага (цаашид НҮБ гэж)-ын Статистикийн комиссоос зөвлөмж болгосон албан ёсны статистикийн шинэчлэлийн үйл ажиллагаа, статистикт их өгөгдлийг ашиглах зэрэг өнөө цагийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж бүрд ҮСХ-ны салбар нэгж, ажилтан ажиллах эсэхийг сайтар судалж, бүтэц, зохион байгуулалтын оновчтой шийдлийг тодорхойлох шаардлагатай.

Статистикийн тухай хуулийн дагуу албан ёсны статистикийн үйл ажиллагааг аймаг, нийслэлд тухайн шатны статистикийн алба удирдан зохион байгуулдаг. ҮСХ-ны дарга Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дугаар заалтад заасны дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн даргыг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлдөг.

Аймгийн статистикийн хэлтсийн албан тушаал, ангилал, зэрэглэлийг ҮСХ-ны даргын 2021 оны А/166 дугаар тушаалаар шинэчлэн баталсны дагуу нийт 129 ажилтан, тодруулбал: 7 орон тоотой хэлтэс 5 аймагт, 6 орон тоотой хэлтэс 15 аймагт, 4 орон тоотой хэлтэс 1 аймагт ажиллаж байна.

ҮСХ-ны даргын 2018 оны А/161 дүгээр тушаалаар нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн бүтэц, орон тоо, албан тушаал, ангилал, зэрэглэлийг шинэчлэн баталсан. НСГ 12, 2 дүүргийн статистикийн хэлтэс 9, 3 дүүргийн статистикийн хэлтэс 8, 1 дүүргийн статистикийн хэлтэс 7, 2 дүүргийн статистикийн хэлтэс 3 орон тоотой, Багахангай дүүрэгт 1 мэргэжилтэн, нийт 68 ажилтан ажиллаж байна.


#### ХҮСНЭГТ 10. АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН АЛБАН ХААГЧДЫН ТОО

| Албан тушаалын нэр  | НСГ | Дүүргийн хэлтэс, орон тоогоор |   |   |   |   | Аймгийн хэлтэс, орон тоогоор |    |   |
|---------------------|-----|-------------------------------|---|---|---|---|------------------------------|----|---|
|                     |     | 9                             | 8 | 7 | 3 | 1 | 7                            | 6  | 4 |
| 1 Дарга             | 1   | 1                             | 1 | 1 | 1 |   | 1                            | 1  | 1 |
| 2 Ахлах мэргэжилтэн | 1   | 1                             | 1 | 1 | 1 | 1 | 1                            | 1  | 1 |
| 3 Мэргэжилтэн       | 8   | 7                             | 6 | 5 | 1 |   | 3                            | 3  | 1 |
| 4 Нягтлан бодогч    | 1   |                               |   |   |   |   | 1                            | 1  | 1 |
| 5 Зохион байгуулагч | 1   |                               |   |   |   |   | 1                            |    |   |
| 6 Хэлтсийн тоо      |     | 2                             | 3 | 1 | 2 |   | 5                            | 15 | 1 |

Төрийн албан хаагчийг томилохдоо Төрийн албаны зөвлөлийн ҮСХ-ны дэргэдэх салбар зөвлөлийн шийдвэрийн дагуу Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан иргэнийг томилж байна. 2021 онд орон нутгийн 17 ажлын байрыг зарлан тусгай шалгалтыг 1 удаа зохион байгуулж, 15 орон тоог нөхсөнөөс 6 дүүрэгт 8, 5 аймагт 7 албан хаагч байна.

Аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт 2021 оны байдлаар нийт 197 ажилтан ажиллаж байна. Нийт ажилтны 25 хувь нь эрэгтэй, 75 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт ажилтны 63.3 хувь нь статистикийн салбарт 6-20 жил ажилласан байна.

**ЗУРАГ 39. АЙМАГ, ДҮҮРЭГ, НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС, ГАЗРЫН АЖИЛТАН, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар**



Нийт ажилтны 62.8 хувь нь 31-45 насных байна. Төрийн албаны тухай хуулийн 46 зүйлийн 46.3-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргахгүй бол 2022 онд 4, 2023 онд 1, 2024 онд 5, 2025 онд 3, 2026 онд 2 албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас чөлөөлөгдөхөөр байна.

Нийт ажилтны 23.4 хувь нь магистр, 76.4 хувь нь бакалавр болон дипломын дээд боловсролтой байна. Нийт ажилтны 28.7 хувь нь статистикч, хүн ам зүйч, 59.6 хувь нь эдийн засагч, нягтлан бодогч, 13.3 хувь нь бусад (багш, инженер, эрх зүйч гм) мэргэжлийнх байна.

Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын дагуу НСГ-ын дарга эрхэлсэн түшмэл, аймгийн статистикийн хэлтсийн дарга ахлах түшмэл, дүүргийн хэлтсийн дарга болон аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн нь дэс түшмэлийн ангилалд хамаардаг.

Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан цалингийн сүлжээгээр ажилтны үндсэн цалинг тогтоож, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу төрийн албан хаагчид ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн үр дүнгийн урамшууллыг цалингийн сангийн хэмжээнээс шалтгаалан улирал бүр олгож чадахгүй байна.

Аймгийн статистикийн хэлтсийн албан тушаалын ангилал зэрэглэлийг шинэчлэн, зохион байгуулагчийн албан тушаалыг нягтлан бодогч болгон өөрчилж албан тушаалын тодорхойлолтыг 2021 оны 11 дүгээр сард шинэчлэн баталсан байна.

Шинэчлэн баталсан нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтод нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, санхүүгийн ил тод байдлыг хангах, мэдээллийг цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, төрийн бус байгууллагын статистикийн мэдээллийг тархаах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, хэлтсийн дотоод үйл ажиллагаа хэвийн явагдахад шаардлагатай ажил үйлчилгээг хариуцан гүйцэтгэхээр тус тус заажээ.

Орон тоог нэмэгдүүлэх боломжгүй тул дээрх олон ажлыг зэрэг гүйцэтгэдэг нягтлан бодогчдын хөдөлгөөн бусад байгууллагатай харьцуулахад өндөр байна. Тухайлбал:

2016 оноос хойш 47 нягтлан бодогч солигдсон байна (2016 онд 4, 2017 онд 6, 2018 онд 10, 2019 онд 9, 2020 онд 12, 2021 онд 6 нягтлан бодогч).

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4-т "Байгууллага архивын орон тооны ажилтантай байх ...", 35 дугаар зүйлийн 35.3-т "Байгууллага орон тооны бичиг хэргийн ажилтантай байна" гэж тус тус заасан. ҮСХ-ны орон нутгийн нэгжийн хувьд архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг НСГ-т мэргэжилтэн, 16 аймгийн статистикийн хэлтэст нягтлан бодогч, 5 аймгийн статистикийн хэлтэст зохион байгуулагч нар тус тус хариуцан гүйцэтгэж байна. Тус хуулийн хэрэгжилтийг хангахын тулд 21 аймаг, нийслэл, 8 дүүрэгт архивын ажилтан 1, бичиг хэргийн ажилтан 1 буюу нийт 60 ажилтан шаардлагатай байна.

Системчилсэн үнэлгээний судалгаанд аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн нийт ажилтны 86.3 хувь нь оролцсон. Судалгаанд оролцсон нийт ажилтны 41.8 хувь нь нэг мэргэжилтэн нь олон салбарын мэдээ хариуцдаг, нягтлан бодогч, санхүү, архив, албан хэрэг хөтлөлт зэрэг олон төрлийн ажил хариуцдаг тул ажлын ачаалал их гэжээ. Одоогийн эрхэлж буй ажлын сэтгэл ханамжийг тодорхойлох асуулгад:

- 54.7 хувь нь ажил, мэргэжилдээ дуртай, ажлын ачаалал ихтэй ч хамт олны уур амьсгал сайхан тул сэтгэл ханамж их;
- 41.7 хувь нь ажлын ачаалал их, хөдөлмөрийн үнэлэмж, цалин бага, илүү цагаар ажиллах шаардлага гардгаас ар гэртээ зарцуулах хугацаа бага тул дунд;
- 3.6 хувь нь нягтлан бодогч санхүү, архив, албан хэрэг хөтлөлт зэрэг ажлуудыг давхар хариуцдаг нь ажлын ачааллыг нэмэгдүүлдэг, хамгийн бага цалинтай, илүү цагаар ажилладаг тул бага гэж үнэлсэн байна.

Дээрх судалгаанд хамрагдсан нийт албан хаагчид ажлын ачаалал ихтэй байгааг дурдсан нь Статистикийн салбарын орон тооны хязгаарыг нэмэгдүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Судалгаанд оролцсон нийт ажилтны 98.8 хувь нь нийгмийн асуудлаа шийдвэрлүүлж байгаагүй, 1.2 хувь нь эмчилгээний зардалд тусламж авсан байна.

ҮСХ жил бүр төсвийн төсөлдөө албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай зардлыг тусгаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлагыг дурдан холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг боловч батлагддаггүй байжээ<sup>7</sup>. Тиймээс ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэдэнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх асуудал шийдвэрлэгдэхгүй, хүсэлт гаргасан албан хаагчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байгааг ҮСХ-ны 2020 оны системчилсэн үнэлгээний тайланд тэмдэглэсэн байна.


Мэргэшсэн ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цалинг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2021 онд аймгийн статистикийн хэлтсийн 49, НСГ-ын 6, дүүргийн статистикийн хэлтсийн 15 албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл, 41 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн, 53 албан хаагчийн цалингийн сүлжээний шатлалыг нэмэгдүүлжээ.

<sup>7</sup> Төсвийн хэмнэлтийн горимд шилжихээс өмнөх жилүүдэд

Системчилсэн үнэлгээний хүрээнд төрийн албаны байгууллагын хувьд ажил үүргийн төстэй, ачаалалтай байдлыг үндэслэн албан тушаалын сарын үндсэн цалингийн мэдээллийг судалж зэрэгцүүлэлт хийсэн. Орон нутаг дахь ҮСХ-ны салбар нэгжийн албан хаагчийн үндсэн цалин Төрийн аудитын байгууллагын салбар нэгжийн албан хаагчийн үндсэн цалингаас сард 628.4-830.0 мянган төгрөг, жилд 7.5-10.0 сая төгрөгөөр тус тус доогуур байна.

**ЗУРАГ 40. ОРОН НУТАГ ДАХЬ НЭГЖИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДСЭН ЦАЛИНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ, тухайн албан тушаалын цалингийн эхний шатлалаар, төгрөгөөр, 2021.12.31-ний байдлаар**



Статистикийн мэдээллийн бодит байдлыг улам сайжруулах, тухайлбал, мэдээлэгч байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүдийн ирүүлж буй статистикийн мэдээллийн бодит байдлыг улам сайжруулахад статистикийн улсын байцаагчийн үүрэг, оролцоо чухал байна. Статистикийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасны дагуу ҮСХ-ны даргын тушаалаар 21 аймаг, нийслэл, дүүргийн газар, хэлтсийн 81 албан хаагчийг статистикийн улсын байцаагчаар томилон ажиллуулж байна. Эдгээр албан хаагчид нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээс гадна тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасан статистикийн улсын байцаагчийн чиг үүргийг давхар хэрэгжүүлж байна. Тодруулбал, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчилд арга хэмжээ авах, харьяалах прокуророор хянуулах зэрэгт хугацаа их шаарддаг. Иймд аймаг, нийслэл, дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан орон тооны статистикийн улсын байцаагчтай болох хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, НСГ-т 2, 6 дүүрэгт тус бүр 2, 3 дүүрэгт тус бүр 1, 21 аймагт тус бүр 1, нийт 38 орон тоо шаардлагатай.

Өрхөд суурилсан судалгааны болон үнийн статистикийн мэдээллийг хугацаанд нь цуглуулах, статистикийн мониторинг, хяналт шалгалтыг хийх зэрэгт НСГ, 21 аймгийн статистикийн хэлтэст жолоочийн орон тоог нэмэх шаардлагатай. Хэдийгээр мэдээлэл цуглуулах үндсэн зорилготой боловч нөгөө талаас мэдээлэл цуглуулж буй судлаач, ажилтны аюулгүй байдлыг ч хангах нэг боломж юм.



## ДҮГНЭЛТ

ҮСХ нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд олон улсын статистикийн байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартын дагуу бодит байдалд нийцсэн чанартай, албан ёсны статистикийн мэдээллээр хэрэглэгчдийг шуурхай хангах үүргээ хангалттай сайн биелүүлсэн байна.

Олон улсын стандартад нийцүүлэн статистикийн аргачлал, ангилал, түүврийн арга зүйг сайжруулан боловсруулснаар албан ёсны статистикийн тооллого, судалгаа, мэдээний хүрээ тэлж, хэрэглэгчдэд тархаах үзүүлэлтийн тоо, хүртээмж нэмэгдсэн байна.

Анх удаа хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эдийн засгийн үзүүлэлт, үндсэн болон хоёрдогч үйл ажиллагаа, ажиллагчдын тоо, борлуулалтын орлогын хэмжээ, байрны эзэмшлийн хэлбэр, коронавируст халдвар (ковид-19) цар тахлын нөлөө, бизнесийн төлөв байдал, зээлтэй эсэх, и-баримтын системд холбогдсон талаарх мэдээллийг Аж ахуйн нэгжийн тооллогоор цуглуулж, мэдээллийн сан бүрдүүлэх суурийг тавьж чаджээ.

ҮСХ нь коронавируст халдвар (ковид-19) цар тахлын хүнд үед улсын хэмжээнд дагаж мөрдөх дэглэмийг сахин онлайн горимд шилжиж, цахим тооллого явуулах, судалгааны мэдээллийг утсаар болон веб аппликөйшнээр цуглуулах аргыг ашиглан статистикийн үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээллийн чанарыг хангахад онцгой анхаарч ажиллажээ. Ялангуяа ААНБ-ын ээлжит тооллогын мэдээлэл цуглуулах ажлыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулсан нь тооллогыг уламжлалт аргаар явуулах үеийн зардлыг нэлээд хэмжээгээр хэмнэсэн байна. Цаашид цахимаар тооллого, судалгааг явуулахад хөдөө орон нутгийн алслагдсан, интернэтийн сүлжээ муу сумын түвшинд программд нэвтрэх, мэдээллээ шивэх технологийн болон бусад шийдлийг олоход Засгийн газар, түүний холбогдох агентлагийн дэмжлэгийг авч хамтран ажиллах шаардлагатай байна.

Тооллогоор хаягийн орон зайн мэдээллийн санд суурилан ААНБ-ын байршлыг тодорхойлж, газар зүйн мэдээллийн санг шинэчилсэн байна.

ҮСХ нь албан ёсны статистикийн мэдээллийн найдвартай шинэ эх үүсвэрийг бий болгох чиглэлээр 2021 онд санаачилгатай ажилласныг онцлох нь зүйтэй. Мэдээлэгчийн ачааллыг бууруулах, мэдээллийн давхардлыг арилгаж, төсвийн зардлыг хэмнэх, статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах “Төрийн нэгдсэн мэдээллийн сан: Төрийн их өгөгдлийг бодлогын шийдвэрт ашиглах нь” төслийн баримт бичиг, танилцуулгыг санаачлан боловсруулсан байна. Энэ төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудад байгаа салангид задгай өгөгдлийн уялдаа эрс сайжирч, мэдээллийн хүрээ, ашиглалт нэмэгдэх, нууцлал, аюулгүй байдлыг хангах замаар хөгжлийн аливаа бодлого боловсруулах, төрийн үйлчилгээг сайжруулах өгөгдлийн санг бий болгох нөхцөл бүрдэх юм.

Статистикийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд төлөвлөсөн хугацаанд мэдээ тайланг цуглуулж, боловсруулан тархаахын тулд мэдээ тайлан ирүүлэх графикийг өмнөх онд батлуулан ажиллаж байгаа нь яам, агентлаг, түүний харьяа газар нэгжүүдээс мэдээллийг хугацаанд нь цуглуулах боломжийг бүрдүүлжээ.

Мэдээ тайлангийн графикт хугацаатай уялдуулан нийтэд тархаах хуваарийг баталж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, мэдээлэл боловсруулалтад статистикчаас ахлах статистикч, хэлтсийн дарга, газрын дарга, нэгдсэн

статистикийн газар, дэд дарга хянасны дараагаар ҮСХ-ны дарга хянаж, тархаалтын нэгжид шилжүүлдэг байна.

Ингэснээр мэдээлэл боловсруулалтыг хугацаанд нь алдаагүй, чанартай хийж, хэрэглэгчдийг үнэн бодитой, хугацааны хоцрогдолгүй мэдээллээр шуурхай хангах боломжийг бүрдүүлж чаджээ.

Албан ёсны статистикийн мэдээллийн чанарт бүтэц зохион байгуулалт, төсөв, орон тооны дутуу байдал сөргөөр нөлөөлөх эрсдэл байна. Тухайлбал:

- Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтэс гэдгийг тухайн шатны Засаг даргаас хараат бус байхаар буюу Засаг даргын дэргэдэх статусыг хасаж, босоо удирдлагатай болгох. Ингэснээр ҮСХ-ны орон нутаг дахь нэгжийн албан хаагчдад ажлын хүрээ, ачаалалд нь дүйцсэн цалин олгож, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг судлах;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу аймаг, нийслэл, дүүргийн статистикийн газар хэлтэст архивын ажилтан 1, бичиг хэргийн ажилтан 1 буюу нийт 60 ажилтан шаардлагатай байна. Статистикийн тооллого, судалгаа зохион байгуулах, хяналт тавих, албан хаагчдын аюулгүй байдлыг хангахад орон тооны жолоочтой болох;
- Аймаг, нийслэлийн Засаг даргатай засаг захиргааны бүх түвшинд албан ёсны статистикийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэдээллийн бодит байдлыг эрс сайжруулахад дараах чиглэлээр онцгой анхаарч хамтран ажиллах шаардлагатай. Үүнд:
  - Жилийн эцсийн мал тооллогын чанарыг улам сайжруулах үүднээс нэгдсэн журмаар тооллого судалгааны зардлыг аймгуудад зардлын ангиллаар тодорхой тусгуулах арга хэмжээ авах;
  - Багийн Засаг даргын 59.1 хувь нь 2021 онд шинэчлэгдсэн тул тэдэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах;
  - Орон нутаг дахь газар, хэлтсийн ажлын өрөө, байрны асуудлыг тухайн шатны Засаг дарга хариуцах талаар тодорхой шийдэлд хүрэх нь зүйтэй;
  - Тухайн шатны статистикийн албаны ажилтны нийгмийн асуудлыг хамтран шийдвэрлэх;
  - Анхан шатны нэгжид статистикийн мэдээ, тайланг хариуцан ажиллаж байгаа багийн Засаг дарга, сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдийг шаардлагатай компьютероор хангах, хүчин чадлыг сайжруулах;
  - Сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний хариуцан ажиллаж байгаа төсөв, төрийн сан болон статистикийн мэдээ, тайлан, тооллого судалгааны хугацаа давхацдагаас ачаалалтай ажилладаг. Анхан шатны нэгжийн статистикийн мэдээ, тайлан, тооллого судалгааны чанар, бодит байдлыг улам сайжруулахад сумын түвшинд ЗДТГ-т статистикийн мэдээ, тайлан хариуцсан ажилтантай болох.

## **САНАЛ**

1. НҮБ-ын Статистикийн комиссоос зөвлөмж болгосон албан ёсны статистикийн шинэчлэлийн үйл ажиллагаа, статистикт их өгөгдлийг ашиглах зэрэг өнөө цагийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж бүрд ҮСХ-ны салбар нэгж, ажилтан ажиллах шаардлагатай эсэхийг сайтар судалж, бүтэц, зохион байгуулалтын оновчтой шийдлийг тодорхойлох;
2. Албан ёсны статистикийн үндсэн зарчмуудын хэрэгжилтийг хангах зорилгоор Статистикийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.

---oOo---

## ХАВСРАЛТ

### ХАВСРАЛТ 1. ҮСХ-НООС ШИНЭЭР БОЛОН ШИНЭЧЛЭН БАТАЛЖ МӨРДҮҮЛСЭН АРГАЧЛАЛ, АНГИЛАЛ, МАЯГТ, АСУУЛГА, НӨХӨХ ЗААВАР, ТҮҮВРИЙН ДИЗАЙН

| №   | Аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын нэр  | Тайлбар    |
|---|--|------------|
| <b>А. Аргачлал</b>                                    |  |            |
| 1   | БОЭЗДС-ийн хүрээний Усны хөрөнгийн данс байгуулах аргачлал   | Шинэ       |
| 2   | БОЭЗДС-ийн хүрээний Хатуу хог хаягдлын данс байгуулах аргачлал   | Шинэ       |
| 3   | БОЭЗДС-ийн хүрээний Газрын ашиглалтын биет хөрөнгийн данс байгуулах аргачлал                           | Шинэ       |
| 4   | Шинжлэх ухаан, технологийн статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал                             | Шинэ       |
| 5   | Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтийн ойлголт, тодорхойлолт, аргачлал                           | Шинэ       |
| 6   | Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал               | Шинэчилсэн |
| <b>Б. Ангилал</b>                                     |  |            |
| 1   | Улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, код  | Шинэ       |
| 2   | Ашгийн бус байгууллагын үйл ажиллагааны ангилал  | Шинэ       |
| <b>В. Үзэл баримтлал, асуулга, маягт нөхөх заавар</b> |  |            |
| 1   | Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны асуулга, үзэл баримтлал  | Шинэчилсэн |
| 2   | Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгааны асуулга, нөхөх заавар          | Шинэ       |
| 3   | "Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал" өрхийн панел судалгааны V шатны асуулга, нөхөх заавар | Шинэчилсэн |
| 4   | Ажил хайгч иргэн, бүртгэлтэй ажилгүй иргэдийн мэдээний маягт, заавар                                   | Шинэчилсэн |
| 5   | Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан ажиллах хүчний албан ёсны статистикийн маягт, заавар    | Шинэчилсэн |
| 6   | Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үнийн судалгааны үзэл баримтлал, маягт, заавар                   | Шинэ       |
| 7   | Зочид буудал, зоогийн газрын мэдээний маягт, нөхөх заавар  | Шинэчилсэн |
| 8   | Нийгмийн даатгалын анхан шатны бүртгэлийн маягт, хөтлөх журам  | Шинэчилсэн |
| 9   | Нийгмийн халамжийн статистикийн мэдээний маягт, нөхөх заавар   | Шинэчилсэн |
| 10  | Оюуны өмчийн салбарын статистикийн маягт, нөхөх заавар   | Шинэчилсэн |
| 11  | Дундаж цалингийн мэдээллийн маягт, нөхөх заавар  | Шинэчилсэн |
| 12  | Жендэр ба хүрээлэн буй орчин судалгааны маягт, нөхөх заавар  | Шинэ       |
| 13  | Цаг уур, агаарын чанарын сарын мэдээний маягт, заавар  | Шинэ       |
| 14  | Өрхөд суурилсан мэдээлэл, харилцаа холбооны технологийн судалгааны үзэл баримтлал, маягт, заавар       | Шинэ       |

| №                                 | Аргачлал, маягт, асуулга, нөхөх зааврын нэр                                  | Тайлбар                              |
|-----------------------------------|--|--------------------------------------|
| 15                                | Хүүхдийн хөдөлмөрийн туршилтын судалгааны асуулга, нөхөх заавар              | Шинэ                                 |
| 16                                | Аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны тооллогын үзэл баримтлал, маягт, заавар | Шинэчилсэн                           |
| <b>Г Тооцоо, тооцоолол</b>        |  |                                      |
| 1                                 | Амьжиргааны баталгаажих доод түвшний 2021 онд мөрдөх тооцоо                  | Шинэчилсэн                           |
| 2                                 | Хүн амын ядуурлын түвшний 2020 оны тооцоо                                    | Шинэчилсэн                           |
| 3                                 | Хүн амын 2020-2050 оны хэтийн тооцоо   | Шинэчилсэн                           |
| 4                                 | Хүн амын боловсролын 2020-2050 оны хэтийн тооцоо                             | Шинэчилсэн                           |
| 5                                 | ДНБ-ийг 2015 оны оноор үнэлсэн тооцоо  | Шинэчилсэн                           |
| 6                                 | Нийгмийн тооцооны матриц   | Шинэ                                 |
| <b>Г Түүвэр судалгааны дизайн</b> |  |                                      |
| 1                                 | Аж ахуйн нэгж, байгууллагын 2020 оны жилийн эцсийн мэдээ                     | Шинэчилсэн                           |
| 2                                 | Усны төлбөр төлөх эрмэлзлийн судалгаа  | Шинэ                                 |
| 3                                 | Малын 2021 оны хагас жилийн түүвэр судалгаа                                  | Түүврийн нэгжийн сонголт             |
| 4                                 | Ажиллах хүчний судалгаа-2021   | Түүврийн анхан шатны нэгжийн сонголт |
| 5                                 | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа-2022                                   | Түүврийн анхан шатны нэгжийн сонголт |
| 6                                 | Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа  | Шинэ                                 |
| 7                                 | Жендер ба хүрээлэн буй орчин судалгаа  | Шинэ                                 |
| 8                                 | Хүн амын мэдээлэл харилцаа холбоо технологийн хэрэглээний судалгаа           | Шинэ                                 |
| 9                                 | Инфляцын хүлээлтийн судалгаа   | Шинэ                                 |
| 10                                | Хүнсний алдагдлын судалгаа   | Шинэ                                 |
| 11                                | Туслах Технологийн түргэвчилсэн үнэлгээ (rATA)-ний судалгаа                  | Шинэ                                 |
| 12                                | Коронавирусын эсрэг дархлал тогтцын судалгаа                                 | Шинэ                                 |
| 13                                | Бизнесийн түүвэр судалгаа  | Шинэ                                 |
| 14                                | Мал болон махны үйлдвэрлэгчийн үнийн судалгаа                                | Шинэ                                 |
| 15                                | Бизнес ба хүний эрх судалгаа   | Шинэ                                 |

**ХАВСРАЛТ 2. ҮСХ-НООС 2021 ОНД ШИНЭЭР БОЛОВСРУУЛСАН ДЭЛХИЙН ТХЗ-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН АРГАЧЛАЛ**

| №  | Код    | Үзүүлэлтийн нэр  |
|----|--------|--|
| 1  | 9.5.2  | 1 сая оршин суугчдад ногдох орон тооны судлаачдын тоо  |
| 2  | 12.3.1 | Дэлхийн хүнсний алдагдлын индекс   |
| 3  | 12.4.2 | Нэг хүнд ногдох аюултай хог хаягдал, устгасан хог хаягдлын эзлэх хувь, устгалын төрлөөр  |
| 4  | 12.5.1 | Хог хаягдлын дахин боловсруулалтын үндэсний түвшин, дахин боловсруулсан материалын хэмжээ, тонноор   |
| 5  | 6.3.1  | Цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэрлэсэн усны эзлэх хувь  |
| 6  | 9.с.1  | Хөдөлгөөнт холбооны сүлжээнд хамрагдсан нийт хүн амын эзлэх хувь, технологийн төрлөөр  |
| 7  | 17.6.1 | 100 оршин суугчдад ногдох суурин интернэтийн өргөн зурвас ашиглах бүртгэлийн тоо, интернэтийн хурдаар  |
| 8  | 2.2.3  | 15-49 насны эмэгтэйчүүдийн дундах цус багадалтын тархалт (хувь), жирэмсэн эсэхээр  |
| 9  | 3.5.1  | Мансууруулах бодис хэрэглэгчдийн эмчилгээнд хамрагдалтын хувь (эмийн эмчилгээ, сэтгэлзүйн эмчилгээ, нийгмийн нөхөн сэргээх-нийгэмшүүлэх тусламж) |
| 10 | 3.5.2  | Тухайн жилд 15, түүнээс дээш насны нэг хүнд ногдох цэвэр спиртийн хэмжээгээр илэрхийлэгдсэн согтууруулах ундааны хэрэглээ, литрээр               |
| 11 | 3.8.1  | Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтын хувь  |
| 12 | 3.8.2. | Өрхийн зардлын дийлэнх хувийг эрүүл мэнддээ зарцуулдаг хүн амын эзлэх хувь   |
| 13 | 3.9.1  | Дотоод болон гадаад орчны агаарын бохирдлоос үүдэлтэй нас баралтын түвшин (10 000 хүнд ногдох)   |
| 14 | 3.9.2  | Баталгаагүй ундны ус, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжаас үүдэлтэй нас баралтын түвшин (10 000 хүнд ногдох)              |
| 15 | 3.b.3  | Зайлшгүй шаардлагатай эмээр тасралтгүй хангах нөөцтэй, бэлэн байдлыг ханган ажилладаг эрүүл мэндийн байгууллагуудын эзлэх хувь                   |

**ХАВСРАЛТ 3. ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ШАЛГУУР  
ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭЭС МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАРЧ БАЙГАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

| Зорилго   | НҮБ-аас<br>баталсан<br>үзүүлэлт<br>ийн тоо | Олон улсад<br>тооцох<br>боломжгүй<br>байгаа<br>үзүүлэлт | Монгол<br>Улсад<br>хамаар<br>алгүй | Үндэсний<br>түвшинд<br>батлагдсан<br>аргачлалтай<br>үзүүлэлтүүд | 2021 онд<br>шинээр<br>нэмэгдсэн<br>аргачлал | Монгол<br>Улсад<br>тооцож<br>байгаа |
|---|--|---|------------------------------------|---|---|-------------------------------------|
| Зорилго 1: Ядуурлыг устгах  | 13   | 5   | -                                  | 7   |   | 8                                   |
| Зорилго 2: Өлсгөлөнг зогсоох  | 14   | 7   | -                                  | 7   | 1   | 7                                   |
| Зорилго 3: Эрүүл мэндийг дэмжих   | 28   | 9   | 2                                  | 24  | 7   | 17                                  |
| Зорилго 4: Чанартай боловсролыг<br>дэмжих                               | 12   | 3   | -                                  | 9   |   | 9                                   |
| Зорилго 5: Жөндөрийн эрх, тэгш<br>байдлыг хангах                        | 14   | 4   | 1                                  | 9   |   | 9                                   |
| Зорилго 6: Баталгаат ундны ус,<br>ариун цэврийн байгууламжаар<br>хангах | 11   | 5   | -                                  | 7   | 1   | 6                                   |
| Зорилго 7: Сэргээгдэх эрчим хүчийг<br>нэвтрүүлэх                        | 6  | 1   | -                                  | 5   |   | 5                                   |
| Зорилго 8: Эдийн засгийн өсөлт,<br>баталгаат ажлын байрыг бий<br>болгох | 16   | 2   | -                                  | 14  |   | 14                                  |
| Зорилго 9: Инновац болон дэд<br>бүтцийг хөгжүүлэх                       | 12   | 6   | -                                  | 9   | 2   | 6                                   |
| Зорилго 10: Тэгш бус байдлыг<br>бууруулах                               | 14   | 9   | -                                  | 5   |   | 5                                   |
| Зорилго 11: Ээлтэй хот, иргэдийн<br>оролцоог дэмжих                     | 14   | 7   | -                                  | 7   |   | 7                                   |
| Зорилго 12: Хариуцлагатай<br>хэрэглээг дэмжих                           | 13   | 10  | -                                  | 5   | 3   | 3                                   |
| Зорилго 13: Уур амьсгалын<br>өөрчлөлтийн үр нөлөөг багасгах             | 8  | 4   | -                                  | 3   |   | 4                                   |
| Зорилго 14: Далай, тэнгисийн<br>нөөцийг хамгаалах                       | 10   | -   | 10                                 | 0   |   | 0                                   |
| Зорилго 15: Хуурай газрын эко<br>системийг хамгаалах                    | 14   | 9   | -                                  | 5   |   | 5                                   |
| Зорилго 16: Энх тайван, шударга<br>ёсыг цогцлоох                        | 24   | 7   | -                                  | 17  |   | 17                                  |
| Зорилго 17: Хөгжлийн төлөөх<br>түншлэлийг бэхжүүлэх                     | 24   | 14  | -                                  | 11  | 1   | 10                                  |
| <b>Нийт</b>   | <b>247</b>                                 | <b>102</b>  | <b>13</b>                          | <b>144</b>  | <b>15</b>                                   | <b>132</b>                          |

**ХАВСРАЛТ 4. ҮСХ-НООС 2021 ОНЫ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ АЖИЛ, САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА**

| <b>№</b> | <b>Шинжилгээ, судалгааны ажил, танилцуулгын нэр</b>   |
|----------|---|
| <b>A</b> | <b>Шинжилгээ, судалгааны ажил</b>   |
| 1        | Ажлын байрыг хадгалах хөнгөлөлттэй зээлийн үр нөлөө   |
| 2        | Хөдөө аж ахуйн статистикийн мэдээлэлд алсын зайнаас тандан судлах арга зүй                            |
| 3        | Дээд боловсрол эзэмшигчдийн мэргэжил ба хөдөлмөр эрхлэлтийн хамаарлын судалгаа                        |
| 4        | Эмэгтэйчүүдийн сэтгэл санааны хүчирхийлэл, хянах зан үйлд өртөхөд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээ   |
| 5        | Коронавирус ба эдийн засаг  |
| 6        | Коронавирусийн нөхцөл байдал, халдварын тархалт   |
| 7        | Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдал 1990-2020 он  |
| 8        | Эдийн засгийн аюулгүй байдлын 2020 оны танилцуулга  |
| 9        | Боловсролын байгууллагын дархлаажуулалт   |
| 10       | Нийгэм, эдийн засгийн хөгжлийг хэмжиж буй байдал  |
| 11       | Мэргэжил ба хөдөлмөр эрхлэлтийн хамаарлын судалгаа  |
| 12       | Салбар хоорондын тэнцлийн шинжилгээ   |
| <b>Б</b> | <b>Салбарын танилцуулга</b>   |
| 1        | Монгол Улсын эдийн засгийн хөгжилд жижиг дунд үйлдвэрлэлийн оруулж байгаа хувь нэмэр-2020 танилцуулга |
| 2        | ДНБ-ий суурь оныг шинэчилсэн танилцуулга (монгол, англи)  |
| 3        | Хэрэглэгчдэд зориулсан статистикийн чанарын тайлан  |
| 4        | Хөрөнгө оруулалтын 2020 оны гүйцэтгэлээрх танилцуулга   |
| 5        | Үндэсний тооцооны данс-2020   |
| 6        | Нөөц, ашиглалтын хүснэгт-2019   |
| 7        | Нийгмийн тооцооны матриц (макро)-2019   |
| 8        | Хүн ам, 2020  |
| 9        | Хүний хөгжлийн индекс, 2020   |
| 10       | Хөдөлмөр, 2020  |
| 11       | Эрүүл мэнд, 2020  |
| 12       | Боловсрол, шинжлэх ухаан, 2020  |
| 13       | Дундаж цалин, 2020  |
| 14       | Гэмт хэрэг, шүүх, 2020  |
| 15       | Биеийн тамир, спорт, 2020   |
| 16       | Соёл урлаг, 2020  |
| 17       | Сүм хийд, 2020  |
| 18       | Хөдөө аж ахуй, 2020   |
| 19       | Төрийн санхүү, 2020   |
| 20       | Инфляц, үнийн өөрчлөлт, 2020  |
| 21       | Дотоодын нийт бүтээгдэхүүн, 2020  |
| 22       | Үндэсний тооцоо, 2020   |
| 23       | Бүс нутгийн ДНБ, 2020   |
| 24       | Хөрөнгө оруулалт, 2020  |
| 25       | Хөдөлмөрийн бүтээмж, 2020   |
| 26       | Аж үйлдвэр, үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчийн үнэ, 2020  |
| 27       | Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал, 2020   |
| 28       | Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл, 2020   |



ХАВСРАЛТ 5. ҮСХ-НООС 2021 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, зорилтот бүлгээр

| №  | Сургалтын сэдэв   | Хамрагдсан   |                                     | Хүний тоо   |
|--|---|--|-------------------------------------|-------------|
|  |   | Байгууллагын нэр   |                                     |             |
| <b>А Хэрэглэгчдэд</b>                              |   |  |                                     | <b>84</b>   |
| 1  | "Статистикийн мэдээллийн сан, түүний хэрэглээ", "Статистикийн мэдээллийг ашиглаж, танилцуулга бэлтгэхэд анхаарах асуудал" | ИНЕГ-ын  | Нислэгийн урсгал, төлөвлөлтийн алба | 9           |
| 2  | Эдийн засгийн статистикийн мэдээний өнөөгийн байдал   | УИХ-ын Тамгын газар  |                                     | 40          |
| 3  | Барилгын салбарын статистикийн мэдээллийн өнөөгийн байдал   | Хот суурины ариутгах, татуургын ашиглалтын үйлчилгээг зохицуулах зөвлөл              |                                     | 15          |
| 4  | Хэрэглээний үнийн статистикийн мэдээллийн өнөөгийн байдал   | Хот суурины ариутгах, татуургын ашиглалтын үйлчилгээг зохицуулах зөвлөл              |                                     | 15          |
| 5  | Статистикийн мэдээллийн төрөл, түүний хэрэглээ  | Тээврийн цагдаагийн алба   |                                     | 5           |
| <b>Б Судалгааны мэдээлэл цуглуулах судлаач нар</b> |   |  |                                     | <b>814</b>  |
| 1  | Эерэг хандлага-ёс зүй сургалт   | Нийслэлийн статистикийн газрын судлаач   |                                     | 29          |
| 2  | Статистикийн үзүүлэлтийн арга зүй, аргачлал   | ӨНЭЗС-ны мэдээлэл цуглуулалтад ажиллах нийслэл, орон нутгийн судалгааны судлаач нарт |                                     | 120         |
| 3  | Хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтийн арга зүй, аргачлал   | Хүүхдийн хөдөлмөрийн туршилтын судалгааны судлаачид                                  |                                     | 70          |
| 4  | Статистикийн шинжилгээ судалгаа хийх чадавх бэхжүүлэх сургалт /3 удаагийн сургалт, давхардсан тоо/                        | Ажиллах хүчний судалгааны судлаачид  |                                     | 316         |
| 5  | ААНБ-ын 2021 оны улсын тооллого зохион байгуулах чиглүүлэх сургалт  | нийслэл, аймгийн статистикийн хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар                  |                                     | 133         |
| 6  | Малын тооны түүвэр судалгаа Бичил уурхайн судалгаа зохион байгуулах   | аймгийн хэлтсийн дарга, ахлах, судлаач нарт  |                                     | 63          |
| 7  | Мал тооллогын бэлтгэл зохион байгуулалт, анхаарах асуудал ОУӨЗХ 2021 судалгаа, үнийн                                      | Аймаг нийслэлийн албан хаагчдад зориулсан сургалт                                    |                                     | 31          |
| 8  | мэдээлэл цуглуулалт, анхаарах асуудлууд   | Аймаг, дүүргийн үнэ цуглуулагчдад зориулсан онлайн сургалт                           |                                     | 52          |
| <b>В Статистикийн ажилтнуудад</b>                  |   |  |                                     | <b>1432</b> |
| 1  | Брэндбүүкийг нэвтрүүлэх, мөрдүүлэх  | Салбарын албан хаагчид   |                                     | 320         |
| 2  | Хувь хүний хөгжил, манлайллын сургалт   | ҮСХ-ны албан хаагчид   |                                     | 320         |
| 3  | Зөрчил шалган шийдвэрлэх тухай  | Статистикийн улсын байцаагч нарт   |                                     | 113         |
| 4  | Статистикийн үзүүлэлтийн арга зүй, аргачлал   | Аймаг, нийслэл, дүүргийн статистикийн хэлтэс, газрын орон                            |                                     | 35          |

| №               | Сургалтын сэдэв   | Хамрагдсан  |             |
|-----------------|---|---|-------------|
|                 |   | Байгууллагын нэр  | Хүний тоо   |
|                 |   | сууцны статистик мэдээ хариуцсан мэргэжилтнүүдэд шинэчлэгдэн батлагдсан маягтын сургалт |             |
|                 |   | Үндэсний статистикийн хороо,  |             |
| 5               | Санхүүгийн программ, төсвийн болон нийслэл, аймгийн статистикийн бусад хууль тогтоомж   | Газар, хэлтсийн нягтлан бодогчдод зориулсан сургалт                                     | 31          |
| 6               | Шинэ ажилтны сургалт  | ҮСХ-ны албан хаагчид  | 70          |
| 7               | Статистикийн үзүүлэлтийн арга зүй, аргачлал   | Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, сумдын жөндөрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд         | 30          |
| 8               | Аж үйлдвэрийн статистикийн мэдээ, тайлан гаргахад анхаарах асуудал  | Аж үйлдвэрийн статистикийн мэдээ, тайланг хариуцсан албан хаагчдад                      | 31          |
| 9               | Бизнес регистрийн сангийн шинэчилсэн программ хангамжийг ашиглах  | ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн холбогдох албан хаагчдад                             | 25          |
| 10              | Сургагч багш бэлтгэх  | ҮСХ-ны албан хаагчид  | 28          |
| 11              | Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох  | ҮСХ-ны албан хаагчид  | 25          |
| 12              | Засгийн газрын 2020 оны 217,218 дугаар тогтоол танилцуулах сургалт  | ҮСХ-ны албан хаагчид  | 20          |
| 13              | Худалдан авах ажиллагааны чадавх бэхжүүлэх  | Төндөрийн үнэлгээний хорооны дарга, нарийн бичиг, гишүүдэд                              | 15          |
| 14              | Аймаг, нийслэлийн сум, дүүрэг, хороодын статистикийн асуудал хариуцсан ажилтнуудад чиглэсэн чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах | Аймаг, нийслэлийн албан хаагчид   | 31          |
| 15              | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга  | ҮСХ-ны албан хаагчдад   | 116         |
| 16              | Анхан шатны мэргэшүүлэх   | ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн холбогдох албан хаагчдад                             | 12          |
| 17              | Архив, албан хэрэг хөтлөлт  | ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн холбогдох албан хаагчдад                             | 53          |
| 18              | Албан хэрэг хөтлөлт, тушаал шийдвэрийн боловсруулалт  | ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн холбогдох албан хаагчдад                             | 89          |
| 19              | Нэгжийн болон ТЖАХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт   | ҮСХ болон аймаг, нийслэл, дүүргийн холбогдох албан хаагчдад                             | 68          |
| <b>Нийт дүн</b> |   |   | <b>2330</b> |

**ХАВСРАЛТ 6. ҮСХ-НООС 2021 ОНЫ ХАГАС ЖИЛД ШИНЭЭР ХИЙСЭН БОЛОН ЗАСВАР, ӨӨРЧЛӨЛТ ХИЙСЭН ПРОГРАММУУД**

| №  | Программын нэр   | Тайлбар    |
|----|--|------------|
| 1  | Статистикийн бизнес регистрийн санг НДЕГ-ын мэдээлэлтэй уялдуулан шалгаж, засварлах программ                           | Шинэ       |
| 2  | Ашиглалтад орсон сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц болон нийтийн байрны хагас, бүтэн жилийн мэдээ (А-ОС-3) | Шинэ       |
| 3  | Буулгасан орон сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, нийтийн байрны хагас, бүтэн жилийн мэдээ (А-ОС-4)        | Шинэ       |
| 4  | Зочид буудлын хүчин чадлын жилийн мэдээ (ЗБ-2)   | Шинэ       |
| 5  | Зоогийн газрын хүчин чадлын жилийн мэдээ (ЗГ-2)  | Шинэ       |
| 6  | Зоогийн газрын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн сарын мэдээ (А-ЗГ-1)  | Шинэ       |
| 7  | Зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн сарын мэдээ (А-ЗБ-1)   | Шинэ       |
| 8  | Тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийн импортын үнийн судалгаа (ТХТҮ-1)  | Шинэ       |
| 9  | Ажиллах хүчний болон хөдөлмөрийн дутуу ашиглалтын судалгааны 2021 программ   | Шинэ       |
| 10 | Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа-2021 программ   | Шинэ       |
| 11 | Цаг уурын хүндрэлийг даван туулж буй байдал судалгааны программ  | Шинэ       |
| 12 | Малчдын аж байдал ба Жендер судалгааны программ  | Шинэ       |
| 13 | Хүүхдийн хөдөлмөрийн судалгааны программ   | Шинэ       |
| 14 | Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны программ   | Шинэ       |
| 15 | Гадаад худалдааны үнийн судалгааны программ  | Шинэ       |
| 16 | Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын программ   | Шинэ       |
| 17 | Дотоод худалдааны сарын мэдээний программ  | Шинэчилсэн |
| 18 | Аж ахуйн нэгж, байгууллагын жилийн эцсийн мэдээ (ААНБ-1, ААНБ-2)   | Шинэчилсэн |
| 19 | Мал төллөлт, төл бойжилтын мэдээний ХАА-1, том малын зүй бус хорогдлын мэдээний ХАА-2 программ                         | Шинэчилсэн |
| 20 | Малын ашиг шимийн гарцын түүвэр судалгаа ХААТС-1.1 программ  | Шинэчилсэн |
| 21 | Зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагааны улирлын мэдээний программ   | Шинэчилсэн |
| 22 | Гадаад худалдааны сарын мэдээний программ  | Шинэчилсэн |
| 23 | Аялал жуулчлалын улирлын мэдээний программ   | Шинэчилсэн |

**ХАВСРАЛТ 7. ОЛОН УЛСЫН САНХҮҮЖИЛТЭЭР ХИЙГДСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, мянган төгрөгөөр**

| №           | Санхүүжилт өгсөн байгууллага  | Төслийн нэр   | 2020 он          |                  | 2021 он          |                  |
|-------------|---|---|------------------|------------------|------------------|------------------|
|             |   |   | Санхүүжилт       | Нийт зарцуулалт  | Санхүүжилт       | Нийт зарцуулалт  |
| 1           | НҮБ Хүн амын сан  |   | 192 657          | 192 657          | 80 289           | 80 289           |
| 2           | НҮБ Хүүхдийн сан  |   | 304 204          | 258 935          | 327 818          | 318 943          |
| 3           | Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага:<br>Статистикийг дэмжих улс орны тайлан |   | 8 861            | -                | 8 861            | 750              |
| 4           | Азийн хөгжлийн банк   | Олон хэмжээт ядуурлын индекс тооцох                                 | 8 736            | -                | 46 496           | 46 496           |
| 5           | Азийн хөгжлийн банк   | Олон улсын өртгийн зэрэгцүүлэлт төсөл                               | 37 015           | 25 387           | 85 037           | 83 685           |
| 6           | Азийн хөгжлийн банк   | Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох                               | -                | -                | 84 982           | 84 982           |
| 7           | Дэлхийн банк  | өрхөд суурилсан судалгаа  | 139 910          | 131 737          | 8 173            | 8 172            |
| 8           | Дэлхийн банк  | Ажиллах хүчний судалгаа   | 112 951          | 108 027          | 18 980           | 2 702            |
| 9           | НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага   | Жендерийн статистик   | 37 606           | 32 294           | 204 816          | 204 816          |
| 10          | НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр  |   | 8 460            | -                | 8 460            | 502              |
| 11          | Германы Цаг уурын хүрээлэн  | Монгол орны цаг уурын хүндрэлийг даван туулах байдлын судалгаа      | 362 405          | 261 390          | 347 169          | 312 483          |
| 12          | Монголын Мянганы сорилтын сан   | Өрхийн ус хангамж, ариун цэврийн байгууламжийг тодорхойлох судалгаа | 147 130          | 147 130          | 7 744            | 7 744            |
| 13          | PIN Олон улсын төрийн бус байгууллага   |   | -                | -                | 13 769           | 13 769           |
| 14          | Дэлхийн банк  | Ухаалаг засаг төсөл   | -                | -                | 119 201          | 119 201          |
| 15          | Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага   | Дотоод шилжих хөдөлгөөний судалгаа                                  | -                | -                | 61 959           | 14 745           |
| 16          | Олон улсын хөдөлмөрийн байгууллага  | Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа                                       | -                | -                | 41 647           | 41 586           |
| <b>Нийт</b> |   |   | <b>1 359 935</b> | <b>1 157 557</b> | <b>1 465 400</b> | <b>1 340 865</b> |